



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2023 • № 66



Б.БАЯРДАВАА: **ЭДИЙН ЗАСГИЙН 2022**
ОНЫ 4.8 ХУВИЙН ӨСӨЛТ БОЛ ЦЭВЭР
БОДЛОГЫН ҮР ДҮН

Тайлбар: Мөнгөн тоногтой хэт хутга



04

ОНЦЛОХ МЭДЭЭ

“ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН
САЛБАРЫН БАЯЛАГ
БҮТЭЭГЧДИЙН
ЗӨВЛӨГӨӨН”-Д
МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ
ОРОЛЦОВ



16

БАЙР СУУРЬ


ОЛОН УЛСЫН
БАЙГУУЛЛАГУУДААС
МОНГОЛ УЛСЫН 2023
ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН
ӨСӨЛТИЙН ТАЛААР
ХЭРХЭН ТӨСӨӨЛСӨН
ТУХАЙ



27

ЗОЧИН

Л.ОЮУН:
МОНГОЛЧУУДЫН
САНХҮҮГИЙН
БОЛОВСРОЛЫН
ГОЛ ХҮНДРЭЛ НЬ
ТӨЛӨВЛӨЛТ



35

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

ИНФЛЯЦЫГ
ТОГТВОРЖУУЛСНААР
ХҮҮГИЙН ТҮВШИН
ЦАР ТАХЛЫН ӨМНӨХ
ТҮВШИН РҮҮ БУЦАХ
БОЛОМЖТОЙ



09

ЯРИЛЦЛАГА

Б.БАЯРДАВАА:
ЭДИЙН ЗАСГИЙН
2022 ОНЫ 4.8
ХУВИЙН ӨСӨЛТ
БОЛ ЦЭВЭР
БОДЛОГЫН ҮР ДҮН



23

НИЙТЛЭЛ

ОЛОН УЛСЫН
ВАЛҮТЫН САНГААС
МОНГОЛ УЛСАД
ӨГСӨН ЗӨВЛӨМЖИД
БИДНИЙ АНХААРАХ
АСУУДАЛ



32

МӨНГӨ УГААХ
ТЕРРОРИЗМТЭЙ
ТЭМЦЭХ

ФАТФ-ААС ЗӨВЛӨМЖ
24-ИЙГ ШИНЭЧИЛЖ,
ЭЦСИЙН
ӨМЧЛӨГЧИЙГ
ТОДОРХОЙЛОХ
ТУХАЙ ШИНЭЧИЛСЭН
АРГАЧЛАЛЫГ
НИЙТЛЭВ



41

СУДАЛГАА

УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН
САНХҮҮГИЙН
САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ
НӨЛӨӨЛӨЛ, ТҮҮНИЙГ
БУУРУУЛАХАД
ЧИГЛЭСЭН АРГА
ХЭМЖЭЭ

“ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН БАЯЛАГ БҮТЭЭГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨН”-Д МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ ОРОЛЦОВ

2023-03-03



Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “Хүнс, хөдөө аж ахуйн салбарын баялаг бүтээгчдийн зөвлөгөөн”-д Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн оролцож, “Хүнсний хангамж, аюулгүй байдал ба төрийн оролцоо” сэдэвт илтгэл тавьж хэлэлцүүлсэн юм. Түүний илтгэлд тус салбарт хийгдэж буй санхүүжилт, төв банкнаас хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний тухай онцлов. Банкны салбар 2021 оны байдлаар хүнс, хөдөө аж ахуйн салбарт 494.3 тэрбум төгрөгийн зээл олгож байсан бол 2022 онд 295 тэрбум төгрөгийн зээлийг 1-3 жилийн хугацаатайгаар олгосон байна. Энэхүү зээлд Засгийн газраас олгож буй хүүгийн дэмжлэг нь 2021 онд 7-7.65 хувь байсан бол 2022 оны байдлаар 10.65 хувь байжээ. Засгийн газраас хэрэгжүүлсэн 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл, хүнсний салбарт олгосон зээлийн үлдэгдэл 2022 оны жилийн эцсийн байдлаар 877.3 тэрбум төгрөг байна. Түүнчлэн Монголбанкны урт хугацаат репо арилжааны зээлийн хүрээнд 47.4 тэрбум төгрөгийн зээл олгожээ.

“ТИНК БАНК” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД МОНГОЛБАНКНЫ ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ МУИС-ИЙН ОЮУТНУУДАД ЛЕКЦ УНШЛАА

2023-03-08



Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Г.Энхтайван Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн оюутнуудад “Төлбөрийн тэнцэл” сэдвээр лекц уншиж, чөлөөт ярилцлагыг өрнүүллээ. Төв банкны зүгээс эдийн засаг, банк санхүүгийн чиглэлээр суралцаж байгаа оюутнуудыг дэмжих, эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар энэ чиглэлийн мэргэжилтнүүдийн мэдлэг, чадавхыг бэхжүүлэх, улмаар судалгааны ажлуудын чанарыг сайжруулахад анхаарч олон талт ажлуудыг тогтмол хэрэгжүүлж байдаг. Тэгвэл эдгээр ажлуудын нэг болох “Тинк-банк” хөтөлбөрийн хүрээнд Монголбанк, МУИС-тай хамтран ажиллаж байгаа бөгөөд эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлгийг үе шаттай зохион байгуулж, судлаачдын судалгааны

ХАРИЛЦАГЧИД ЗӨВЛӨХ БАНКНЫ МЭРГЭЖИЛТНҮҮДЭД СЕРТИФИКАТ ГАРДУУЛЛАА

2023-03-23



Монголбанк, Монголын Банкны Холбоо, Шпаркассэ банкны Монгол дахь сан хамтран банк санхүүгийн мэргэжлийн сургалт, стандартын үйл ажиллагаа явуулах “Сургалтын шинэ институт байгуулах төсөл”-ийн хүрээнд Харилцагчид зөвлөх банкны мэргэжилтний батламж гардууллаа. Энэхүү төсөл нь банкны салбарт Олон улсын стандартыг нэвтрүүлж, банкны үндсэн ажилтны ур чадварыг дээшлүүлэх, чадавхийг бэхжүүлэх, урт хугацаанд Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангахад чиглэгддэг. Иймд иргэдтэй шууд харилцах банкны ажилтныг нэн тэргүүнд чадавхжуулан, иргэдэд зөвлөгөө өгөх ба бусад шаардлагатай мэргэжлийн ур чадварт суралцуулах зорилго бүхий харилцагчид зөвлөх банкны мэргэжилтнийг сургах онол, практик хослуулсан сургалт бөгөөд 8 банкны 124 оролцогчид амжилттай хамрагдлаа.

“ДЭЛХИЙН МӨНГӨНИЙ ДОЛОО ХОНОГ-2023” ОЛОН УЛСЫН АЯНЫГ 10 ДАХЬ ЖИЛДЭЭ ТЭМДЭГЛЭЛЭЭ

2023-03-28



Олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага /OECD/-аас санаачилсан хүүхэд, залууст санхүүгийн мэдлэг түгээх “Дэлхийн мөнгөний долоо хоног-2023” олон улсын аяныг манай улс 14 хоногийн турш амжилттай хэрэгжүүлээ. Энэ жил тус аян нь “Санхүүгээ зөв удирдаж, ирээдүйгээ бүтээцгээе” гэж уриаг дэвшүүлж, байгаль орчин болон эдийн засгийн тогтвортой байдлын төлөө хүн бүр ухаалаг хэрэглээг сонгохын ач холбогдлыг ойлгуулахад чиглэв. Манай улс энэхүү уриалга дор орон нутгийг хамруулсан үйл ажиллагааг зохион байгуулж, “Хувь хүний санхүүгийн төлөвлөлт” үндсэн агуулга бүхий сургалтууд зохион байгуулж, хүүхэд залуучуудын дунд сонирхолтой тэмцээн уралдааныг зохион байгууллаа.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНД ТАЛУУД ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА

2023-03-30



Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд 3-5 жилийн хугацаатай олгох санхүүжилтийн гэрээг Монголбанк, Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, арилжааны банкууд хамтран байгууллаа. Засгийн газрын 2023 оны 63 дугаар тогтоолоор хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих 5-6 хувийн хүүтэй, хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкны эх үүсвэрээр санхүүжүүлж, Засгийн газраас хүүгийн зөрүү 13 хувийг хариуцан олгохоор шийдвэрлэсэн. Энэ хүрээнд арилжааны 10 банкаар дамжуулан эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын зориулалтаар уг зээлийг олгох бөгөөд 2023 оны төсөвт хүүгийн хөнгөлөлтөд зориулж 135.5 тэрбум төгрөгийг тусгажээ. Цаашид зээлийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулснаар гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгчдэд үйлдвэрлэлээ өргөжүүлэх, шинээр үйлдвэр байгуулах, технологийн шинэчлэл хийх замаар ашиг орлогоо нэмэгдүүлэх боломж нээгдэхийн дээр бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг дээшлүүлэх нөхцөл ч бүрдэнэ хэмээн үзжээ.

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН БҮТЭЭЛИЙГ ОЛОН НИЙТЭД ДЭЛГЭЛЭЭ

2023-04-14 11:33




Үнэт металл, үнэт чулуу болон тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид, мөн энэ салбарын оролцогчдын үйл ажиллагааг идэвхжүүлэх, дэмжих, бүтээгдэхүүн, үйлчилгээг нь олон нийтэд таниулан сурталчлах зорилготой “Mongolian Jewellery and Metal Expo” үзэсгэлэн “Мишээл экспо” танхимд 4 сарын 13-16-ны өдрүүдэд болж өнгөрлөө. Тус үзэсгэлэн нь хоёр дахь удаагаа зохион байгуулагдаж байгаа бөгөөд үнэт металл, үнэт чулуугаар бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, уламжлагдан ирсэн соёлын өв тээгч, уран дархчууд, гоёл чимэглэлийн худалдаа эрхлэгч албан байгууллага иргэдийг нэгтгэн, салбарын нэгдсэн мэдээллээр хангах, бүтээгдэхүүн үйлчилгээг төр болон олон нийтэд сурталчлан таниулах, борлуулахад дэмжлэг үзүүлэх зорилготой байв. Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Соёлын яам, Стандарт, хэмжил зүйн газар болон холбогдох бусад байгууллагаас хамтран зохион байгуулсан энэ удаагийн үзэсгэлэнд Монголбанк дэмжигч байгууллагаар оролцож, Эрдэнэсийн сангийн үйл ажиллагаа болон алт худалдан авалттай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл өгч ажиллалаа.

ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСҮРЭН ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САНГИЙН СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ УУЛЗАЖ, САНАЛ СОЛИЛЦОВ

2023-04-27



Монголбанкны Ерөнхийлөгч 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр Олон Улсын Валютын Сангийн Монгол улс дахь суурин төлөөлөгч Юүн Сёк Хүн болон үүрэгт ажлаа хүлээж авахаар зэхэж буй шинэ суурин төлөөлөгч Тигран Погосиян нарыг хүлээн авч уулзлаа. Уулзалтын эхэнд Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн ОУВС-гийн хамтын ажиллагаа, туслалцаанд өндөр ач холбогдол өгдөг гэдгээ онцлоод, Монгол улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, банкны салбарын шинэчлэлийн талаар харилцан санал солилцов.



ФИТЧ АГЕНТЛАГ МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ "В", ТӨЛӨВИЙГ "ТОГТВОРТОЙ" ХЭВЭЭР ҮЛДЭЭСНИЙГ БАТАЛГААЖУУЛЛАА

Фитч агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг "В", төлөвийг "Тогтвортой" хэвээр үлдээснээ 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдөр зарлав. Тус байгууллагаас гаргасан хэвлэлийн мэдээлэлд дараах үндэслэлүүдийг харгалзан Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг хэвээр үлдээснийг дурджээ. Үүнд:

- **Гадаад секторын эмзэг байдал.** Монгол улсын засаглалын үзүүлэлтүүд, нэг хүнд ногдох орлого "В" үнэлгээтэй бусад оронтой харьцуулахад сайн байна. Гадаад өрийн түвшин өндөр, гадаад валютын нөөц бага байгаа энэ үед гадаад санхүүжилт, БНХАУ-д нийлүүлэх түүхий эдийн экспортоос ихээхэн хамааралтай байгаа нь зээлжих зэрэглэлийн үнэлгээг хязгаарлаж байна.
- **Өсөлтийн сэргэлт.** Фитч агентлаг уул уурхайн салбарын сэргэлт, дотоод эрэлтээс шалтгаалан 2023 онд Монгол Улсын бодит ДНБ-ий өсөлт 5 хувьд хүрч, 2024 онд эрчимжихээр таамаглаж байна. БНХАУ Ковидын эсрэг бодлогоо сулруулснаар нүүрсний экспорт хурдацтайгаар сэргэж байгаагийн зэрэгцээ ирэх 1-2 жилийн хугацаанд хил дээрх төмөр замыг бүрэн ашиглаж эхэлснээр экспортын хүчин чадал нэмэгдэнэ. 2023 оны 3 дугаар сард Оюутолгой гүний уурхайн үйл ажиллагаа нээлтээ хийсэн бөгөөд аажмаар үйлдвэрлэл

нь нэмэгдэхээр байна. Бусад уул уурхай, дэд бүтцийн төслүүд дунд хугацааны өсөлтийг дэмжинэ.

- **Гадаад санхүүжилт** тогтворжиж байна. Экспортын сэргэлт, гадаадын шууд хөрөнгө оруулалт урсгал дансны алдагдлыг бууруулна. Тодруулбал, Фитч агентлагаас Монгол Улсын урсгал дансны алдагдал 2022 онд 2.3 тэрбум ам.доллар (ДНБ-ий 13 орчим хувь) болж өссөн хэмжээнээс 2023-2024 онд 1.7-1.8 тэрбум ам.доллар (ДНБ-ий 9 орчим хувь) болж буурна гэж төсөөлж байна. 2022 оны 8 дугаар сарын эцэст 2.7 тэрбум ам.долларт хүрээд байсан гадаад валютын албан нөөц 2023 оны 4 дүгээр сарын эцэст 3.7 тэрбум ам.долларт хүрээд байна. Гэсэн хэдий ч 2021 оны эцэст 24 хувь байсан нийт хадгаламжийн долларжилт 2023 оны 3 дугаар сарын эцэст 37 хувьд хүрснийг тэмдэглэсэн байна.
- **Гадаад өр.** Монгол Улсын цэвэр гадаад өр 2023 онд ДНБ-ий 160 хувьтай тэнцэж байгаа нь "В" голчоос 6 дахин их үзүүлэлт бөгөөд үүний 30 гаруй хувийг хувийн компани хоорондын зээл (ГШХО), 20 гаруй хувийг Засгийн газрын хоёр болон олон талт зээл эзэлж байна. Засгийн газрын өрийн хэмжээ 2021 онд ДНБ-ий 61 орчим хувьтай тэнцэж байсан бол 2022 онд нэрлэсэн өсөлт,

төсвийн тэнцэл сайжирснаар ДНБ-ий 60 хувь болж буурсан. Фитч агентлагаас “В” голчтой уялдуулан өрийн хэмжээ буурахын зэрэгцээ Засгийн газрын баталгаа бүхий Хөгжлийн банкны бондыг төлснөөр гадаад өр 2024 он гэхэд ДНБ-ий 55 орчим хувьд хүрч буурна гэж таамаглаж байна. Гэсэн хэдий ч Засгийн газрын гэнэтийн өр төлбөр нэмэгдэж болзошгүйг тэмдэглэсэн байна.

- **Эргэн төлөлтийн зохицуулалт.** 2023 оны үлдсэн хугацаанд Засгийн газар 150 сая гаруй ам. долларын гадаад өрийн эргэн төлөлтийг хийнэ. 2023 оны 1 дүгээр сард татсан 650 сая ам.долларын санхүүжилтээр 2023 оны 5 дугаар сард төлөгдөх бондуудын эргэн төлөлтийг хийсэн. Монгол Улсын Хөгжлийн банк Засгийн газрын баталгаа бүхий бондын эргэн төлөлтийг 2023 оны 12 дугаар сард хийх зорилгоор 30 тэрбум иен (220 сая ам.доллар)-ийн эх үүсвэрийг бүрдүүлээд байна. Монгол Улсын Засгийн газар 2024 онд 680 сая ам.долларын эргэн төлөлт хийх хуваарьтай байна.
- **Төсвийн алдагдал** бага байна. Фитч агентлагаас Монгол Улсын төсвийн алдагдлыг 2023-2024 онд ДНБ-ий 1 хувиас бага байхаар авч үзсэн байна. 2021 онд төсвийн алдагдал ДНБ-ий 3 хувьтай тэнцэж байсантай харьцуулахад 2022 оны төсвийн гүйцэтгэл мэдэгдэхүйц сайжирсан байгааг тэмдэглэсэн байна. Тус байгууллагаас эрдэс баялгийн бус алдагдал 11-12 орчим хувь байгаа нь 2020 онд 21 хувь байснаас буурсан үзүүлэлт боловч 2022 оны төсвийн тодотголд хуульчилсан тэтгэвэр, хүүхдийн тэтгэмжийг нэмэгдүүлсний үр дүн хэмээн тэмдэглэсэн байна.
- **Түүхий эдийн хамаарал, эрсдэлүүд.** Гадаад валютын орох урсгалын 90 хувийг, Засгийн газрын орлогын 30 хувийг бүрдүүлдэг түүхий эдийн орлогоос маш мэдрэмтгий байна. Фитч агентлагийн тооцоолсноор нүүрсний экспортын хэмжээ суурь үзүүлэлттэй харьцуулахад 10 хувиар буурахад урсгал дансны алдагдлыг 500 сая ам.доллар (ДНБ-ий 4 хувь)-оор нэмэгдүүлж, Засгийн газрын орлогыг 100 сая ам.доллараар бууруулахаар байна.
- **Инфляц, мөнгөний бодлогын төлөв.** Фитч агентлаг 2022 онд дунджаар 15 гаруй хувь байсан жилийн дундаж инфляц 2023 онд 12 хувь, 2024 онд 9 хувьд хүрч зорилтоос бага зэрэг өндөр байна хэмээн таамаглаж байна. ОХУ-д тавьсан олон улсын хориг арга хэмжээ нь импортын өртгийг нэмэгдүүлж байгаа хэдий ч БНХАУ-тай хийх худалдаа хэвийн түвшинд хүрсэн, дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнэ буурах нь инфляцыг бууруулна гэж үзэж байна. Монголбанк 2022 онд бодлогын хүүг нийтдээ 7 нэгж хувиар нэмэгдүүлж, мөн оны 12 дугаар сард бодлогын хүүгээ 13 хувь хүртэл өсгөөд байна.
- **Банкны систем** тогтвортой байна. Нийт зээлийн 10 орчим хувийг чанаргүй зээл эзэлж байгаа ч нэрлэсэн дүнгийн өндөр өсөлт, хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрүүд, ипотекийн зээлийн эргэн төлөлтийг зогсоосон зэрэг нь активын чанарыг сайн харагдуулж болзошгүй байгааг дурдсан байна. Монголбанкнаас системийн ач холбогдолтой банкуудын активын чанарын үнэлгээг хийж гүйцэтгэсэн бөгөөд системийн нөлөө бүхий 5 банкны 3 нь IPO хийгээд байна.

Б.БАЯРДАВАА: ЭДИЙН ЗАСГИЙН 2022 ОНЫ 4.8 ХУВИЙН ӨСӨЛТ БОЛ ЦЭВЭР БОДЛОГЫН ҮР ДҮН



Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваатай ярилцлаа.

Ковидын цар тахлын дараах эдийн засгийн сэргэлттэй зэрэгцэн мөнгөний хатуу бодлого хэрэгжиж байна. Дэлхийн Төв банкууд бодлогын хүүгээ сулруулахад зорихгүй байх шиг байна. Тиймээс нөхцөл байдлыг төдий л сайжирна гэж харахгүй байна уу?

Төв банкны үндсэн зорилт нь инфляцыг тогтвортой байлгах. Ковидын цар тахлын хүндрэл нь ихэнх төв банкуудын зорилтод сорилт үүсгэсэн. Инфляцыг 2-3 хувьд байлгах зорилготой төв банкуудын инфляц 9, 10 хувьд хүрч, 3 дахин нэмэгдсэн. Харин манай инфляцын хувьд зорилтоосоо 2 дахин нэмэгдсэн. Сүүлийн үеийн хандлагыг харвал 2022 оны дөрөвдүгээр улирлаас эхлэн дэлхий нийтэд инфляц буурах хандлага ажиглагдаж байгаа ч их хөшүүн байна. Ийм орчинд төв банкуудын инфляцыг тогтворжуулахад чиглэж байгаа мөнгөний бодлого нь тодорхой түвшинд хатуу төлөв байдалтай үргэлжлэхээс өөр аргагүй. Хатуу төлөв гэдэг нь харьцангуй ойлголт бөгөөд бодлогын хүүнүүд өснө ч гэсэн үг биш буурахгүй ч гэсэн үг биш юм. Дэлхийн санхүүгийн

зах зээлийн жишиг хүүг тогтоодог Холбооны Нөөцийн банкны суурь хүү өсөж байгаа ч зарим улс орнууд бодлогын хүүгээ бууруулж эхлэх шинж ажиглагдаж байна. Энэ нь инфляцын бууралттай уялдаж байгаа болохоос биш мөнгөний бодлогын төлөв зөөлөн төлөвт шилжсэн гэсэн үг биш юм. Харин мөнгөний бодлого хэт хатуу төлөвт удаан үргэлжлэх, хэт хатуу байхаас сэргийлж байгаа хэрэг.

Инфляцын цаашдын хандлагыг авч үзвэл ямар хандлагатай байна вэ?

Дараагийн шатанд инфляцад нөлөө үзүүлж болзошгүй хэд хэдэн хүчин зүйл байна. Нэгдүгээрт, валютын ханшийн нөлөө. Цар тахал бол үүний дараагаар олон улсын харилцаанд үүссэн өнөөгийн хүндрэлтэй нөхцөл байдлын үед АНУ-ын доллар дэлхийн бараг бүх валютуудын эсрэг чангарсан буюу бусад валютууд ам.долларын эсрэг суларсан тул тухайн улсуудын хувьд импортын барааны үнийг дотоодын зах зээлд өсгөж байна. Хоёр дахь хүчин зүйл нь ковидын дараах сэргэлтийн үед бизнес эргэн сэргэж байгаатай холбоотойгоор

хөдөлмөрийн зах зээл дагаад сэргэж байна. Хөдөлмөрийн зах зээл дагаж сэргэхийн хэрээр хэрэглээнд зарцуулагдах орлого нэмэгдэж байна. Дагаад өндөр инфляцын үед цалингийн өсөлтүүд инфляцын сөрөг нөлөөг бууруулах зорилгоор бодит орлогын сөрөг нөлөөг бууруулах зорилгоор нэмэгдэж байна. Энэ нь нэг талаасаа орлогыг нэмэгдүүлж, хэрэглээг тэтгэх замаар эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөөтэй боловч нөгөө талдаа бизнесийн хувьд үйл ажиллагааны зардал. Энэ утгаараа дэлхий нийтээр зардлын инфляц үүсэх вий гэсэн болгоомжлолтой байна. Гурав дахь том хүчин зүйлийн хувьд, хэдийгээр цар тахлын үед үүссэн тээвэр логистик, нийлүүлэлтийн гинжин хэлхээний доголдол илаарших тал руугаа явж байгаа ч бүрэн арилаагүй байна. Энэ нь нийлүүлэлт, тээвэртэй холбоотойгоор үүсэж байгаа зардал цар тахлын өмнөх хэвийн үеийн түвшиндээ хараахан хүрээгүй байна. Тэгэхээр энэ нь нэг талаасаа инфляцад бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн үнэд нөлөөтэй. Мөн глобалчлал, нийлүүлэлтийн гинжин хэлхээнд доголдол томоохон өөрчлөлт

орох эрсдэлтэй байна. Дэлхий нийтээрээ нийлүүлэлтийн харилцан хамааралтай орчинд үйлдвэрлэл, бизнес хийгдэж байгаа. Энэ нь доголдоод ирэхээр бизнесийн үйл ажиллагаанд тодорхой хэмжээний зардал үүсгэж байна. Хамгийн тод жишээ бол цар тахлын үед Орос, Украйны олон улсын харилцааны нөхцөл байдлын үед нийлүүлэлтийн доголдоос сэргийлэхийн тулд илүү их хэмжээний бараа материалын нөөцтэй байх нөхцөл байдалтай тулгарсан. Энэ нь хүссэн хүсээгүй эргэлтийн хөрөнгийн зардлыг бизнесүүдэд бий болгосон. Инфляцад ч нөлөөгөө үзүүлж байгаа. Эрэлтийн талаасаа цар тахлын дараагаар эдийн засаг сэргэж байгаатай холбоотойгоор ялангуяа Америк, Европ гэх мэт том зах зээлүүдийн хувьд хөдөлмөрийн зах зээл нь маш сайн сэргэлттэй байгаа нь бизнесийн борлуулалтын орлого дээр эерэг нөлөө үзүүлж, эрэлтийн шинж чанартай болгоомжлолыг бий болгож байгаа учраас төв банкнууд дараа үеийн нөлөөгөөс сэргийлж, инфляц ужгирахаас сэргийлж, тодорхой хэмжээнд мөнгөний бодлогоо хатуу төлөвт хадгалж байна.

Унаж байсан манай эдийн засаг хэвийн түвшинд хүрч, 4.8 хувийн өсөлтийг өнгөрсөн онд үзүүлсэн шүү дээ. Инфляц ч 16 хувьд хүртэл өссөн удаатай ч одоо бол 12 руу буучихсан байгаагаас эргээд харахад үүнд бодлогын шийдвэрийн нөлөө хэр байв?

Монгол Улсын хувьд 2020 онд эдийн засаг 4.6 хувийн уналттай, 2021 онд цар тахлаас аажим сэргээд 1.6 хувийн өсөлттэй, 2022 онд таны хэлснээр 4.8 хувийн өсөлттэй гарсан. 2022 оны 4.8

хувийн өсөлт бол цэвэр бодлогын үр дүн гэж харж байна. Яагаад ингэж дүгнэж байна вэ гэхээр олон улсад үүссэн геополитикийн асуудал бүрэн шийдэгдээгүй буюу гадаад орчин таатай биш байсан. Худалдааны том түнш, экспортын 80-90 хувийн худалдан авагч тал болох Хятадын зах зээл цар тахлын хатуу зохицуулалт үргэлжилж, хил хаалттай гэж болохоор байсан. Энэ нь экспорт, импортын тээвэр, экспортын эрэлтэд сөрөг нөлөөтэй байсан. Үүний тод илрэл нь юу байв гэхээр тээвэр логистикийн хүндрэл 2022 онд бүрэн шийдэгдээгүй, эхний хагаст маш хүндрэлтэй нөхцөл байдалд явсан. 2021 оны хоёрдугаар улирлаас эхлээд 2022 оны эхний гурван улирал дуустал Монгол Улс нүүрсний экспортын орлогогүй байсан. Ийм орчинд уул уурхайн салбараас, гадаад эдийн засгийн орчноос дотоод эдийн засгийн өсөлтийг тэтгэх эерэг нөлөө үндсэндээ байхгүй байв. Ийм үед эдийн засгийн өсөлт хаанаас бий болсон бэ? гэсэн асуултын хариулт бол худалдаа, үйлчилгээ, ХАА, боловсруулах салбар, хэрэглээ, бүтээн байгуулалт гэх мэт уул уурхайн бус салбаруудын өсөлтөөс бий болсон үүний ард зээл санхүүжилтийн бодлого, салбаруудын зохицуулалтууд байгаа.

Зээлийн санхүүжилт, мөнгөний бодлого хэрхэн эдийн засгийн өсөлтийг суурь болсон талаар тодруулах шаардлагатай байх.

Тэгэхээр уул уурхайн салбарын доголдолын сөрөг нөлөөг зээл санхүүжилтийн бодлогоор нөхсөн гэсэн үг. Өөрөөр хэлбэл, уул уурхайн салбараас орж ирэх орлого доголдоход дотоодын санхүүгийн зах зээл дээр эх

үүсвэрийн дутагдлыг бий болгосон. Энэ нь эцэстээ зээлдэгч нарын хувьд эргэлтийн хөрөнгийн зээл, хөрөнгө оруулалтын зээл гээд эдийн засагт шаардлагатай байгаа санхүүжилтийн доголдолд оруулсан. Харин 2018, 19, 20 он гээд цар тахал хүртэл төсөв дээр ч, гадаад валютын нөөцөд ч тодорхой хэмжээний санхүүгийн нөөц хуримтлуулсан байсан нь 2020 оноос эхэлсэн цар тахал, түүнтэй үргэлжлээд залгасан олон улсын харилцааны хүндрэлтэй нөхцөл байдлын орчинд дотоод эдийн засгийг дэмжих бодлогын орон зайг бий болгож өгсөн. Үүнийг зохицуулагч байгууллага болох Төв банк, Санхүүгийн зохицуулах хороо, Засгийн газартай хамтраад хэрэгжүүлэхдээ зээлийн төлөвлөгөө байдлаар санхүүжилтийн эх үүсвэрийг нийлүүлсэн. Ихэнхдээ төв банкнаас репо санхүүжилт, ипотекийн зээлийг хэрэгжүүлсэн бол санхүүжилтийн дийлэнхийг арилжааны банкнуудын өөрийнх нь эх үүсвэрийг дайчилж эдийн засгийн эргэлтэд оруулсан. Үүнийг хийсэн хөшүүрэг нь Засгийн газраас олгосон хүүний татаас байсан. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэгжүүлсэн зээлийн эргэн төлөлтийн хуваарийн өөрчлөлт, хойшлуулалт зэрэг нь зээлийн тасалдалаас сэргийлэхийн зэрэгцээ санхүүгийн тогтвортой байдлыг авч үлдэхэд нөлөөлсөн. Энэ нь эдийн засгийн сэргэлтийн суурь болсон. Эдийн засаг 2020 оны -4.6%-ийн уналтаас 2022 онд 4.8% болж байхад 2021 онд зээлийн өсөлт 2020 оны 3.4 хувийн уналтаас 9.7 хувь, 2022 онд 19 хувь болж өссөн юм.

Манай хамгийн том нийлүүлэгч зах зээл бол Хятад улс. Хятадын зах зээл

дээр үл хөдлөх хөрөнгийн салбар энэ цаг үед сэргэж буйтай холбоотойгоор манай түүхий эдийн экспорт нэмэгдэх гарц байна гэж харж байна. Тэгэхээр Хятадын зах зээлийг хэрхэн яаж харж байна. Энэ боломжийг ашиглах тал дээр ямар бодлого хэрэгжүүлж болох вэ?

БНХАУ-ын дэлхийд 1, 2-т орох том эдийн засгийн өсөлт 2022 оны эхнээс эргээд цар тахлын бодлогоо зөөлрүүлээд эргэж нээгдэж байгаа нь Монголын эдийн засаг төдийгүй, дэлхийн эдийн засагт томоохон нөлөө үзүүлж байгаа. Үүний дамжиж орж ирж байгаа шууд суваг бол эрдэс бүтээгдэхүүний үнийн зах зээл дээр эерэг нөлөөллийг үүсгэж, эерэг хүлээлтийг бий болгож байна. Гэхдээ Хятадын эдийн засаг өөрөө 5 орчим хувиар өснө гэдэг бол энэ том хэмжээтэй зах зээл дээр том үзүүлэлт, том хэмжээгээр эдийн засаг өсөх гэж байна гэсэн үг. Бидний анзаарах ёстой зүйл нь Хятадын эдийн засаг өөрөө гадаадын хөрөнгө оруулалтад тулгуурласан хөгжлийн загвараас илүүтэйгээр дотоод эдийн засгийн чадавхад тулгуурласан хөгжлийн загвар руу шилжиж байгааг анхаарах ёстой. Нөгөө талд энэ том хэмжээний зах зээл дээр аливаа төрлийн бүтээгдэхүүнийхээ эрэлтийг хангах тал дээр сайн бизнесийн харилцаатай байх ёстой. Нүүрс, төмрийн хүдэр, зэс гэх мэт уул уурхайн бүтээгдэхүүнээс гадна юун түрүүнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн мах, ноолуур гэх мэтчилэн бусад олон төрлийн бараа бүтээгдэхүүнийг Хятадын зах зээлийн үйлдвэрлэлийн гинжин хэлхээ рүү холбож чадах

юм бол дэлхийн зах зээлтэй холбогдож чадна гэсэн үг.

Тэгвэл бид одоо энэ зах зээл рүү тогтвортой нийлүүлэлт хийж чадахаар байна уу?

Бидний хамгийн түрүүнд харах бүтээгдэхүүн бол ноолуур. Чанараараа ч тэр, хэмжээгээрээ ч Дэлхийд өрсөлдөж чадахуйц том салбар. Бид өнөөдөр 300 сая долларын ноолуур харьцангуй түүхий байдлаар экспортолж байгаа боловч, нэмүү өртөг шингээгээд нэгээс хоёр шат ахиулахад энэ салбараас олох орлогыг 2-3 дахин нэмэгдүүлэх бололцоотой. Тиймээс төр засгаас, санхүүгийн сектороос тасралтгүй дэмжих, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, сайжруулах ёстой. Харин махны зах зээлийн хувьд нийлүүлэлтийг гинжин хэлхээ, бүтээмжийг сайжруулахгүйгээр экспортод мах гаргах бололцоо байхгүй. Тодорхой хэмжээний мах экспортоллоо гэхэд л дотоодын зах зээл дээр хомсдол үүсэж, дотоодын зах зээл дээр үнийн өсөлт, инфляц болж байна. Тэгэхээр махны нийлүүлэлт тогтвортой биш, салбар нь өөрөө эргэлтэд бүрэн ороогүй, тогтвортой ажиллаж чадахгүй, бүтээмж нь муу байна гэдгийг маш тодорхой харуулж байна. 70 сая малыг яавал тогтвортой махны нийлүүлэлтийн эх үүсвэр болгож, эдийн засгийн эргэлтэнд оруулах вэ? Гэдэг нь олон зүйлстэй холбогдож байна. Тухайлбал, нийгмийн хавтгайрсан халамжтай ч холбогдоно. Цаашилбал, малаас гаралтай түүхий эд, дагавар бүтээгдэхүүнийг боловсруулах аж үйлдвэрийн салбар, бүр цаашилбал хөдөө аж ахуйн салбар малчдад олгож байгаа нийгмийн халамж энэ бүх зүйлүүдтэй уялдаж байна. Хөдөө аж ахуйн салбарыг төр засаг,

Гадаад худалдааны үйлчилгээний экспорт, импортын тэнцлийг сайжруулах орон зай хангаттай байгаа болохыг дараах орлого зарлагын дүнгээс харьцуулав

Үүнд:

Эрүүл мэндийн үйлчилгээний орлого \$17 сая ам.доллар, төлбөр \$137 сая ам.доллар, тэнцэл -\$120 сая ам.доллар алдагдал

Боловсролын үйлчилгээний орлого \$18 сая ам.доллар, төлбөр \$469 сая ам.доллар, тэнцэл -\$451 сая ам.доллар алдагдал

Аялалын үйлчилгээний орлого \$191 сая ам.доллар, төлбөр \$358 сая ам.доллар, тэнцэл -\$167 сая ам.доллар алдагдал

Ачаа тээврийн үйлчилгээний орлого \$546 сая ам.доллар, төлбөр \$1076 сая ам.доллар, тэнцэл -\$530 сая ам.доллар алдагдал

Санхүүгийн үйлчилгээний орлого \$27 сая ам.доллар, төлбөр \$226 сая ам.доллар, тэнцэл -\$199 сая ам.доллар алдагдал

Төлбөрийн тэнцлийг сайжруулахын тулд экспортын орлогыг дараах байдлаар нэмэгдүүлсэнээр гарах үр дүн

Үүнд:

1. Нүүрсний экспортын орлого 1.6-2.4 тэрбум ам.доллараар нэмэгдэх.

* Нүүрсний экспортын биет хэмжээ жилийн 40-45 сая тонн, хилийн үнэ 150 ам.долларт хүрэх

2. Нүүрсний тээврийн орлогыг 250 сая ам.доллараар сайжруулах

* Нүүрсний тээврийн зардлын -тэй тэнцэхүйц

3. Аялал жуулчлалын орлогыг 150-200 сая ам.доллараар нэмэгдүүлэх

* Аялалын зардлын -тэй тэнцэхүйц

Эдгээр нөхцлүүд зэрэг биелвэл төлбөрийн тэнцэл энэ онд 800 саяаас 1.7 тэрбум ам.долларын ашигтай гарах боломжтой.

санхүүгийн системээс бүх төрлийн сувгаар буюу дотоод, гадаадын эх үүсвэртэй хөнгөлөлттэй зээлээр дэмжиж, төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг. Харин үр дүн хаана байна гэдгийг сайн үнэлэх ёстой, тэгж байж дараагийн хөтөлбөр, арга хэмжээнүүдээ хэрэгжүүлэх шаардлагатай. Харин Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар хэрэгжүүлж байгаа хүнсний аюулгүй байдал, хүнсний хангамж хөтөлбөрийг хүрээнд уг нь нийлүүлэлтийн гинжин хэлхээг хөгжүүлж, тогтвортой, өрсөлдөх чадвартай тогтвортой салбарыг л хөгжүүлэхийг зорьж байна.

Хүнс, ХАА бүтээгдэхүүний үнийн инфляцад үзүүлэх нөлөөг хэрхэн харж байна вэ?

Динамик шинжилгээнээс харахад нийт инфляцын 40-50%-ийг мах, гурил, сүү, хүнсний ногоо, шатахуун гэсэн 5 бүтээгдэхүүн үүсгэдэг. Өнөөдрийн инфляцыг бүлгүүдээс задалж үзвэл дотоодын хүнсний бүлгийн жилийн инфляц 27%, энэ нь нийт 11.3%-ийн инфляцын 36%-ийг бүрдүүлж байна. Хүнсний инфляцынхаа 47%-ийг гурил болон гурилан бүтээгдэхүүн, 22%-ийг махны үнэ бүрдүүлж байна. Тэгэхээр энэ салбарыг тогтолцоо болон нийлүүлэлтийн гинжин хэлхээнийх нь хувьд ингэж сайжруулахаас өөр арга байхгүй. Идэш бэлтгэж, ургац хурааж байгаа намрын улирлаас эхлээд хавар, зуны эхэн саруудад чанартай бүтээгдэхүүнийг тогтвортой үнээр хэрэглэж чаддаг нийлүүлэлт, хадгалалтын тогтолцоог л бүрдүүлэх хэрэгтэй.

Эцэст нь Монголбанк эдийн засгийн өсөлтийн төсөөллийг тодруулья.

ЭЗӨ-ийг 2023 онд 4 хувиар төсөөлсөн. Гэтэл Олон Улсын байгууллагууд 5 хувь гэж өөдрөгөөг харж байна?

Сүүлийн 3 жилийн хугацаанд тэр гэх боломжгүй тодорхой бус орчинд бодлого боловсруулагч нар шийдвэр гаргаж байгаа. Нэг эрсдэлтэй нөхцөл байдал шийдвэрлэгдэхэд дараагийн шинэ эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн ийм орчинд явж ирлээ. Энэ утгаараа бид хамгийн консерватив, хамгийн болгоомжтой төсөөллүүдийг хийж байна. Үүнийг хийхдээ шинэ нөхцөл байдал үүсч, бидний хүлээлтээс давсан нөхцөл байдал үүсэхэд түүнийг тодорхой хэмжээнд баталгаажуулж байж төсөөллийн шинэчлэл руу оруулж байна. Өнгөрсөн оны эцэст хийсэн төсөөллөөр эдийн засгийн өсөлт 4% байх төлөвтэй байсан бол одоо 1-р улирлын гүйцэтгэлд үндэслэн энэхүү төсөөллийг шинэчилж байна. Одоогийн байдлаар уул уурхайн бус салбарын хүлээлтээс 1 орчим функтээр бага гарч байна. Харин уул уурхайн салбар нь нүүрсний экспортын гүйцэтгэлтэй холбоотойгоор хүлээлтээс давлаа. Түүнчлэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгын хүрээнд банкны системээс хүнсний салбар, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах хүрээнд олгож байгаа зээл олголтыг чиглүүлж байна. Энэ нь нийт эдийн засаг дахь зээл, санхүүжилтийн нөхцөл, хүнсний чиглэлийн салбарт тодорхой хэмжээний эерэг нөлөө үзүүлнэ. Тэгэхээр энэхүү мэдээллүүдийг нэгтгэн төсөөллөө шинэчлээд 6 сард болох мөнгөний бодлогын хорооны хуралд танилцуулах болно.

МӨНГӨН ТОНОГТОЙ ХЭТ ХУТГА

1940 -1950 оны үе
Баруун монгол хийц
Жин: 1567 гр
Хутга: 30 см, хуй: 20 x 3
см, хэт: 6.5 x 8 см



Энэхүү хэт хутгыг Говь-Алтай аймгийн Шарга сумын малчин Зулын Яринпэл хэрэглэж байсан бөгөөд 1988 онд Улсын банкны Эрдэнэсийн санд худалджээ.

Модон бариул, бүдүүн гурив бүхий баруун монгол хийцийн хэт хутга. Хуйг нь арьсаар бүрж, мөнгөн бүслүүрээр тоноглосон энгийн хийцтэй боловч бэл,

тээгийг цул мөнгөн ембүү, бэлний гурвалжин туухайнд цэцэг, навч сийлсэн чимэглэлтэй. Мөн хэт нь өлзий хээ бүхий мөнгөн тоногтой ажээ.

МӨНГӨН ТЭЭГ SILVER BELT DEVICE

Жин: 210 гр
Өндөр: 5 см
Мөнгө, цутгамал





МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Мөнгөний бодлогын хорооны шийдвэр

(I улирал)

Бодлогын хүүг хэвээр хадгалах



● Бодлогын хүү



Хүүний коридор +1, -1



Төсвийн шинжтэй аливаа төрлийн санхүүжилтийг зогсоож, импортын дарамтыг бууруулах



Банкуудын гадаадын зах зээлээс бонд болон зээл хэлбэрээр шинээр татсан 360 хоног хүртэлх хугацаатай эх үүсвэрийг заавал байлгах нөөц (ЗБН)-ийн шаардлагаас чөлөөлөх



Банкууд хэт богино хугацаат эх үүсвэр ихээр татах, гаднаас татах эх үүсвэрийн хугацаа богинсож, шилжилт хийж буй эсэхийг тогтмол судлах, бодлогын арга хэмжээнд шаардлагатай өөрчлөлтүүдийг тухай бүр оруулах



Мөнгөний бодлогын шийдвэрт нөлөөлсөн хүчин зүйлс

1

Глобал эдийн засагт инфляцын эрч саарч, инфляцын хүлээлт тогтворжиж байгаатай холбоотойгоор дэлхийн томоохон төв банкууд бодлогын хүүгээ эрчтэй нэмэгдүүлэхээ сааруулаад байна.

2

Инфляц тээврийн зардал, импортын барааны үнээр дамжин буурч энэ оны эцэст зорилтын дээд интервалын орчимд ирж цаашид алгуур буурахаар хүлээгдэж байна.

3

БНХАУ-ын Ковидын бодлого суларч, экспортын гол түүхий эдийн үнэ нэмэгдэж байна. Үүнийг дагаад эдийн засгийн цаашдын төлөв өмнөхөөс сайжирлаа.

4

Дэлхийн эдийн засгийн өсөлт болон түүхий эдийн үнэ цаашид буурах эрсдэл хэвээр, гадаад орчны тодорхой бус байдал өндөр байна.

5

Хэдийгээр инфляц алгуур буурч энэ оны сүүлээс зорилтот түвшинд хүрэхээр хүлээгдэж байгаа боловч инфляцад ханшийн дам нөлөө, эрэлтийн хүчин зүйлсийн нөлөө нэмэгдэх эрсдэлтэй байна.

6

Дэлхийн эдийн засгийн өсөлт энэ онд өмнөх оноос саарч гадаад эрэлт буурах, дэлхий дахинд үүсээд буй нийлүүлэлтийн сүлжээний доголдол улс орнуудын геополитикийн асуудлаас үүдэн үргэлжлэн даамжрах эрсдэл байсаар байна.

7

Цаашид эдийн засгийн сэргэлт, инфляцын өрнөл, нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлс, олон улсын харилцааны нөхцөл байдалтай уялдуулан мөнгөний бодлогын дараагийн алхмуудыг авч хэрэгжүүлнэ.

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДААС МОНГОЛ
УЛСЫН 2023 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН
ТАЛААР ХЭРХЭН ТӨСӨӨЛСӨН ТУХАЙ БАЙР
СУУРЬ БУЛАНД ОНЦОЛЛОО.

5.2%

Дэлхийн
банк

4.5%

Олон Улсын
Валютын Сан

5.4%

Азийн
Хөгжлийн банк

АХБ-ны Монгол Улс дахь
суурин төлөөлөгч Павит
Рамачандран

АЗИЙН

(2023 оны 4 дүгээр сарын 4)

Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-ын эдийн засаг дахин нээлттэй болж, ашигт малтмалын бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэн, дотоодын эрэлт сэргэснээр Монгол Улсын эдийн засаг цар тахлын дараах өсөлтийн мөчлөгт шилжиж байна. Энэ нь гадаад, дотоодын санхүүжилтийн нөхцөлүүд эрс чангарснаас үл хамааран өмнөх сөрөг хүлээлтүүдийг өөрчилж байна хэмээн Азийн Хөгжлийн Банк (АХБ)-наас өнөөдөр танилцуулсан тайланд дурджээ.

АХБ-наас жил бүр эрхлэн гаргадаг *Азийн Хөгжлийн Төлөв* эдийн засгийн тайлангийн энэ оны 4 дүгээр сарын шинэ дугаарт өгүүлснээр Монгол Улсын эдийн засаг экспорт, уул уурхайн салбарын сэргэлт, түүний тээвэр болон бусад салбаруудад үзүүлж буй эерэг нөлөөгөөр 2022 оны 4.8%-ийн өсөлтөөс сэргэж, 2023 онд 5.4%, 2024 онд 6.1%-иар тус тус өсөх төлөвтэй байна.

“КОВИД-19 цар тахал, БНХАУ-тай хиллэдэг худалдааны боомтууд дахь хязгаарлалтууд, Украин дахь Оросын Холбооны Улс (ОХУ)-ын халдлага зэрэг гадаад орчны сөрөг нөлөө, цочролын улмаас Монгол Улсын эдийн засагт өнгөрсөн гурван жилийн турш хүндрэл бий болсон. Гэвч экспортын эрэлт сэргэсэн болон хямралын эсрэг хэрэгжүүлсэн бодлогын хариу арга хэмжээний нөлөөгөөр эдийн засаг сэргэх замдаа ороод байна” хэмээн АХБ-ны Монгол Улс дахь суурин төлөөлөгч Павит Рамачандран тэмдэглээд “Гэхдээ эдийн засгийн өсөлтийг илүү хүртээмжтэй болгохын тулд өсөлтийн түвшинг хадгалахын зэрэгцээ өндөр инфляцыг бууруулах зайлшгүй шаардлагатай” гэж мэдэгдлээ.

Үргэлжлүүлэн ноён Павит Рамачандран “Монгол Улсын ойрын хугацааны бодлогын зорилтууд нь экспортыг нэмэгдүүлэх, инфляцыг бууруулах, төсөв, мөнгө, макро зохистой бодлогоор макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чиглэх юм. Түүнчлэн, нийт хуримтлалыг нэмэгдүүлж эдийн засгийн дархлааг сайжруулах зорилгоор улсын секторын удирдлага болон санхүүгийн салбарт бүтцийн шинэчлэл хийх нь чухал байна. Хувийн хэвшлийн хөгжилд тулгуурласан эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих эерэг орчныг бүрдүүлэн, өсөлтийг дунд хугацаанд хадгалахын тулд Монгол Улс хөрөнгө оруулалтын орчны цогц шинэчлэлийг боловсруулж хэрэгжүүлэх боломжтой” хэмээн тодруулав.

Бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт доголдох, гадаад худалдаа тасалдах эрсдэл буурахтай уялдан жилийн дундаж инфляцын түвшин 2023 онд 10.9%, 2024 онд

ХӨГЖЛИЙН**БАНК:**

8.7% болж буурахаар байна. Гэвч төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах болон дотоод эрэлт нэмэгдэх нөлөөгөөр инфляц төв банкны зорилтот түвшин болох 6%-иас өндөр хэвээр байх төсөөлөлтэй байгаа юм. Цаашид төсвийн зардлыг хумих нь макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих бөгөөд хувийн хэвшил шахагдах сөрөг нөлөөг багасгана. Гадаад худалдаа тасалдах эрсдэл багасаж, тээврийн зардал буурахтай уялдан үйлчилгээний дансны алдагдал буурахын зэрэгцээ барааны экспорт нэмэгдэхтэй холбоотойгоор төлбөрийн урсгал дансны алдагдал буурахаар байна.

Эдийн засгийн төлөв байдлыг суурь төсөөллөөс бууруулж болзошгүй эрсдэлүүд бий. Үүнд, Украин дахь ОХУ-ын халдлагын улмаас эдийн засагт учруулж буй сөрөг нөлөөллүүд улам даамжрах, КОВИД-19 цар тахлын вирусийн шинэ хувилбар үүсэж халдварын шинэ давлагаа бий болох, ашигт малтмалын бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дэх үнэ огцом буурах, дотоодод улс төрийн нөхцөл байдал муудах болон нүүрсний оффтайк гэрээнүүдийн төлбөрийн тэнцэл дэх сөрөг нөлөө нэмэгдэх зэрэг болно.

АХБ нь Ази, Номхон далайн бүс нутагт нэн ядуурлыг арилгах хүчин чармайлтаа үргэлжлүүлэхийн зэрэгцээ хүртээмжтэй, тогтвортой, эрсдэлийг даван туулах чадвартай хөгжлийг бүс нутагт цогцлоохын төлөө тууштай ажиллаж байна. Анх 1966 онд байгуулагдсан тус банкны нийт 68 гишүүн орны 49 нь тухайн бүс нутагт оршдог.



Дэлхийн Банкны суурин төлөөлөгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Тиласони Бенжамин Мусуку

ДЭЛХИЙН БАНК:

(2023 оны 4-р сарын 19)

Монгол Улсын эдийн засаг 2022 онд 4.7 хувиар өссөн бол цаашид уул уурхайн салбарын олборлолт болон экспорт тэлж, цар тахлын дараа үйлчилгээний салбар үргэлжлэн сэргэснээр 2023 онд 5.2 хувиар өсөх төлөвтэй байна.

Дэлхийн Банкаас сүүлд гаргасан Монголын эдийн засгийн тойм тайлангаас харахад хөдөлмөрийн зах зээл сайжрахын хэрээр өрхийн хэрэглээ тогтвортой түвшинд хадгалагдаж, улсын хөрөнгө оруулалт тэлснээр энэ онд эдийн засгийн өсөлтийг дэмжих хүлээлттэй байна. Харин өвөлжилтийн хүндрэлээс шалтгаалан хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл саарах төлөвтэй. Цар тахалтай холбоотой хязгаарлалт суларснаар үйлчилгээний салбар, тэр дундаа аялал жуулчлалын салбарын идэвхжил үргэлжлэн сэргэж, дээрх сөрөг нөлөөг нөхөх боломжтой.

Нөгөөтэйгүүр, ажиллах хүчний оролцооны түвшин Ковид-19 цар тахлын өмнөх үеэс доогуур түвшинд хэвээр байна. Үүний зэрэгцээ өндөр инфляц, улсын салбарын өр, төсөвт дарамт учруулж болохуйц эрсдэлүүд, гадаад секторын тэнцвэргүй байдал болон уул уурхайн салбараас хэт хамааралтай байдал зэрэг нь эдийн засагт тулгамдаж буй гол асуудлууд болоод байна.

“Уул уурхайн бус салбарыг бэхжүүлэх нь эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах, ажиллах хүчний, ялангуяа эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг

нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой” хэмээн Дэлхийн Банкны суурин төлөөлөгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Тиласони Бенжамин Мусуку хэлэв. Тэрээр мөн “Байгалийн баялгийн бус салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах нь бүтээмжийг дээшлүүлж, түүхий эдийн үнийн цочролд өртөх эмзэг байдлыг бууруулах боломжтой” болохыг онцоллоо.

Эдийн засгийн хэтийн төлөвт сөргөөр нөлөөлж болзошгүй хэд хэдэн эрсдэлүүдийг тайланд дурджээ. Тухайлбал хөгжингүй орнууд мөнгөний бодлогын төлөвөө хүлээлтээс илүү хэмжээгээр чангаруулах, геополитикийн хурцадмал байдал даамжрах, Засгийн газрын өр төлбөрүүд их хэмжээгээр хуримтлагдах, нүүрсний экспортын гэрээтэй холбоотой тодорхой бус байдал хэвээр хадгалагдах зэрэг нь эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байна.

Уул уурхайн үйлдвэрлэл эрчимжсэнээр эдийн засгийн өсөлт 2024-2025 онуудад 6 хувиас давж өсөх төлөвтэй байна. Гэвч цаашдаа тогтвортой өсөлтийг хангах, дотоод, гадаад болон цаг уурын цочмог нөлөөлөлд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэхийн тулд эдийн засгийн төрөлжилтийг дэмжсэн бүтцийн өөрчлөлтүүд чухал ач холбогдолтой хэвээр байна. Илүү идэвхтэй, динамик хөдөлмөрийн зах зээлийг бий болгосноор уул уурхайн бус салбарын бүтээмжийг нэмэгдүүлж, улмаар эдийн засгийг солонгоруулах үйл явцад дэмжлэг үзүүлэх боломжтой.

Ажиллах хүчний хөдөлмөр эрхлэх боломжийг өргөжүүлэх, тэдний ур чадварыг сайжруулах, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн цогц системийг бий болгох шинэчлэлийг хийх замаар хөдөлмөрийн зах зээлийг бэхжүүлэх тухай бодлогын хэд хэдэн саналыг тайланд дэвшүүлжээ. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлэн, залууст илүү их боломж бололцоог олгож, хотын оршин суугчдыг хөдөлмөрийн зах зээлд татан оролцуулснаар ажиллах хүчний оролцоо тэлж, улмаар Монгол Улсын хөгжилд томоохон түлхэц болох юм.

Төсвийн тогтвортой байдал, аливаа цочмог нөлөөлөлд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэхэд төсвийн сахилга бат, засаглалын реформууд чухал ач холбогдолтой болохыг тайланд онцолсон байна. Түүнчлэн Монгол Улсын гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, төлбөрийн тэнцлийн дарамтыг багасгахад валютын ханшийн уян хатан байдлыг хангах, хөрөнгө оруулалтын төслүүдийг үр ашиг, зардал, ач холбогдлоос нь хамааруулан эрэмбэ дараатай хэрэгжүүлэх, экспортын орлого ба санхүүгийн хөрөнгийн орох урсгалыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг авах нь зүйтэй зэрэг зөвлөмжүүд багтжээ.




СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ

3 дугаар сарын мэдээ

ИНФЛЯЦ

Бодлогын хүүг 2022 оны 12-р сард 1.0 нэгж хувиар өсгөж 13.0 хувьд хүргэв.



Эх сурвалж: Монголбанк

2023 оны 3 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд жилийн инфляц 12.2 хувьтай гарав.




ХҮНСНИЙ ҮНИЙН ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ УЛААНБААТАР ХОТ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

M2 МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

M2 мөнгөний нийлүүлэлт 2023 оны 3 дугаар сард 30.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 16.8% -иар өсөв.



M2-ийн өсөлт байршуулалт талаас




M2-ийн өсөлт эх үүсвэр талаас




Эх сурвалж: Монголбанк

ЗЭЭЛ

2023 оны 3 дугаар сард банкуудын нийт зээлийн үлдэгдэл өмнөх оноос 5.2%-иар өсөж 23.0 их наяд төгрөгт хүрэв.



2023 оны 3 дугаар сарын байдлаар чанаргүй зээл 9.6%-тай байна.



Зээлийн жилийн өсөлт, салбарын ангиллаар




Эх сурвалж: Монголбанк


ИПОТЕКИЙН ЗЭЭЛ



Ипотекийн нийт зээлийн үлдэгдэл **6,663.4** тэрбум төгрөгт хүрэв.



Шинээр олгосон ипотекийн зээлийн хүү



Зээлдэгчдийн тоо




Эх сурвалж: Монголбанк

ХҮҮ



Зээлийн хүү, хадгаламжийн хүүний зөрүү



Зээлийн хүү*, хугацаатай хадгаламжийн хүү (*хөнгөлөлттэй зээл оруулснаар)




Эх сурвалж: Монголбанк


ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ



Төлбөрийн тэнцлийн динамик, сая ам.доллар




МУ-ын төлбөрийн тэнцэл 2023 оны эхний 3 сарын урьдчилсан байдлаар **79.6** сая ам.долларын ашигтай гарсан.



Урсгал ба хөрөнгийн дансны бүтэц



Санхүүгийн дансны бүтэц



Эх сурвалж: Монголбанк



ОРОН СУУЦНЫ ИПОТЕКИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 4 дүгээр 30-ны
өдрийн байдлаар


Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд Монголбанк, Засгийн газар болон банкуудын эх үүсвэрээр нийт 7.1 их наяд төгрөгийн зээлийг 113.8 мянган өрхөд олгоод байна.

2023 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 233.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийг 2.3 мянган өрхөд Монголбанк болон банкуудын эх үүсвэрээр олгоод байна (Дүрслэл 1).


Цар тахлын хуулийн дагуу хөтөлбөрийн зээлийн эргэн төлөлтийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр 2020 оны 4 дүгээр сараас 2022 оныг дуустал 5 удаа хойшлуулсан (Дүрслэл 2). Сүүлийн буюу 5 дахь удаагийн төлбөр хойшлуулалтаар 3.4 их наяд гаруй төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй 63.2 мянган зээлдэгчийн хүсэлтийг үндэслэн төлбөрийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр хойшлууллаа. Дээрх зээлдэгчид 2020 оны 4 дүгээр сараас эхлэн 2022 оныг дуустал нийт 978.4 орчим тэрбум төгрөг (418.9 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 559.5 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр)-ийн төлбөрийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр хойшлуулсан байна.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль/ Цар тахлын хууль/-ийн хэрэгжих хугацаа 2022 оны эцсээр дуусгавар болсноор хөтөлбөрийн зээлийн эргэн төлөлт хэвийн төлөгдөж байна. “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам” болон “Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам”-ын дагуу ипотекийн хөтөлбөр хэвийн хэрэгжиж байна.

Дүрслэл 1. Ипотекийн хөтөлбөрийн зээл олголт (тэрбум ₮)



Дүрслэл 2. Ипотекийн төлбөр хойшлуулсан зээл (тэрбум ₮) болон зээлдэгчийн тоо



Түүнчлэн, цар тахлын тухай хууль, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл, “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”, Сангийн сайд, Монгобанкны Ерөнхийлөгчийн хамтарсан тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу 2023 оны эхний хагаст багтаан Засгийн газарт ипотекийн хөтөлбөрийг шат дараатай шилжүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.




Монголбанкны үнэт металл худалдан авалт 2023 оны 4 сар

Үнэт металл худалдан авалт

Монголбанк 2023 оны 4 дүгээр сард 998.7 кг үнэт металл худалдан авч, оны эхнээс өссөн дүнгээр 3.2 тонн үнэт металл худалдан аваад байна.


Оны эхнээс өссөн дүнгээр Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 234.3 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны хэлтэс 360.0 кг үнэт металл тус тус худалдан авсан.



эх сурвалж: Монголбанк

Үнэт металлын үнэ

Монголбанкны үнэт металл худалдан авах үнийг дэлхийн зах зээл дээрх үнээр тогтоодог. 2023 оны 04 дүгээр сард **дундаж үнэ 224,794** төгрөг байв.



эх сурвалж: Монголбанк



ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САНГААС МОНГОЛ УЛСАД ӨГСӨН ЗӨВЛӨМЖИД БИДНИЙ АНХААРАХ АСУУДАЛ

С.Дэмбэрэл Монголбанкны Эдийн засгийн сургалт,
судалгааны хүрээлэнгийн захирал

ОУВС-ийн шинжээчид өнгөрөгч 2022 оны 1 дүгээр улиралд Монголд ирсэн айлчлалынхаа дараа макро эдийн засгийн төлөв байдал, мөнгө, төсвийн бодлогын дүн шинжилгээг хийж холбогдох дүгнэлтүүд, зөвлөмжөө гаргадаг. Үүнийг холбогдох гол институтууд болох Сангийн яам, Монголбанк судлан өөрчлөлт хийх, бодлогын үйл ажиллагаагаа зохицуулах гэх мэтээр хариу үйлдэл хийдэг уламжлалтай. Гэхдээ эдгээр дүгнэлт, зөвлөмж нь мөнгө төсвийн бодлого баталдаг гол институт болох УИХ-ын анхааралд тэр бүр орж, гаргаж буй хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт нь тусдаггүй. Эдийн засагчид ч тэдгээрийг онцлон анхаарч олж уншиж, санал дүгнэлтээ гаргадаггүй.

Гэтэл эдгээр дүгнэлт, зөвлөмж нь Монгол Улсад хэрэгтэй олон чухал санаа, шийдлийг агуулсан байдаг тул ихээхэн анхаарвал зохих баримт бичиг юм. Тиймээс хамгийн сүүлд ОУВС-ийн шинжээчдийн гаргасан "Mission statement"-ийн нийтлэлийг илүү ойлгомжтой болгох зорилгоор POWER гэсэн хэлбэрт оруулж зохих гаргалгаа, шийдлүүд буюу дүгнэлтүүдийг гаргасан (**Rationales** гэсэн хэсэгт)

POWER дүн шинжилгээ

(ОУВСангийн 2022 оны 10 сард гаргасан "Mission Statement"-д хийсэн дүн шинжилгээ)

Positives

- Ковидын дараах сэргэлт, ялангуяа уул уурхайн бус сектор, ХАА-д
- Глобал үнэ өсөж байгаа болон экспортын саад хязгаарлалтууд суларсан
- Өрхийн бодит орлого нэмэгдсэн, 2022 оны эхнээс тэтгэврийн доод хэмжээ үлэмж нэмэгдсэн, цалин хөлсний байдал сайжирсан
- 2022|23 онд сэргэлт үргэлжлэхээр байна
- Нүүрсний экспорт нэмэгдэнэ.
- Оюу толгойн далд уурхайн эхлэл 2023 онд нэлээд түлхэц өгнө.
- Дотоод эрэлт үргэлжлэн өсөж, богино хугацаанд өсөлтийг дэмжинэ.
- Бодит ДНБ 2022 онд 2.5%, 2023 онд 4% байна. Өсөлт гол нь уул уурхайн секторын хувь нэмрээр хангагдана.
- Дунд хугацаандаа өсөлтийн төлөв нь потенциал өсөлтөөс дээгүүр байна.
- Махны үйлдвэрлэл нэмэгдэх, хүнс, эрчим хүчний үнэ глобал түвшинд буурч буй болон Оросын нефть бүтээгдэхүүний хөнгөлөлттэй үнэ зэрэг нь инфляцын болон гадаад дарамтыг хөнгөвчилнө.

Opportunities

- Хүчтэй реформ хийх боломж бага ч Монгол Улсын эдийн засгийн хүч чадал УИХ-аас ирэх саруудад батлах бодлогын багц ялангуяа 2023 оны төсвөөс гол нь хамаарах болно.
- Валютын ханшийн уян хатан байдлыг эрс нэмэгдүүлэх нь хувийн хэвшлийн гадаад өр төлбөрийн менежментэд урамшуулах түлхэц болж импортыг тогтворжуулах, дам сөрөг нөлөөг багасгана.
- Төсвийн болон төсөвтэй адилтгах бодлогыг чангатгах
- ГВУН-ийг нэмэгдүүлэх, позицийг сайжруулахын тулд Монголбанкны интервенцийг тогтмол бус болгох, эдийн засгийн бүх нэгжүүдийн гадаад өр төлбөрийн менежментийн төлөвлөгөө, төсөөллүүдийн талаар бүрэн хэмжээний мэдээллээр хангагдсан байх ёстой
- ТӨҮГ-дын ХО-ыг оролцуулаад төсвийн ХО-ыг эрс танаж, эрэмбэлэх шаардлагатай
- ЗГ, Монголбанктай гадаад төлбөр тооцооны уялдаа холбоогоо сайжруулах
- Импортын татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг зогсоох
- Санхүүгийн нөхцөлүүд хатуурч буйтай холбогдон Монгол Улсын гаргасан бондын удирдлага, хөгжлийн банкны тэнцлийг сайжруулах
- Инфляцыг бууруулахын тулд төсвийн шинжтэй үйл ажиллагааг 2023 онд зогсоох
- Банкны секторын гүйлгээний чадварыг дээшлүүлэх, Монголын банкинд хөрөнгийн их хэмжээний

алдагдлаа багасгах, үйл ажиллагааны бие даасан байдлаа сайжруулах, мөнгөний бодлогын итгэлийн түвшинг нэмэгдүүлэх боломж олгох

- Монголбанкны мөнгөний бодлогын талаар авсан арга хэмжээнүүд зүйтэй бөгөөд цаашдаа банкны секторын тогтвортой байдлыг хангах, төсвийн шинжтэй арга хэмжээнүүдэд үл оролцох, инфляцын хүлээлтийг аргамжих, инфляцын хүчин зүйлүүдэд болон мөнгөний бодлогын төлөвөө олон нийтэд тодорхой тайлбарлаж байх
- ЗГ-ын зүгээс Монголбанкны инфляцыг тогтворжуулах хүчин чармайлтыг а) нийлүүлэлтийн гацааг арилгах б) төсвийн чамбай байдлыг хангаж дотоод эрэлтийг багасгах с) төсвийн татаас болон нийгмийн эмзэг хэсэгт хандсан бодлогын дэмжлэгээ зорилтын шинж чанартай болгох гэх мэт замаар дэмжих

Weaknesses

- Дотоод гадаад тэнцлүүд алдагдсан
- Дэд бүтцийн хөрөнгө оруулалт нь импортыг нэмэгдүүлж байна
- ЭТТ оффтек гэрээнүүд Хятадын барилгын компаниудын санхүүжилтэд чиглэв
- Капиталын гадагшлах урсгал, депозитын долларжилт, олон улсын санхүүгийн нөхцөлүүд хүндэрснээр валютын ханшид дарамт үзүүлж 22|10 сард 17.5% жилийн дүнгээрээ суларч ГВУН 2.8 тэрбум болтол буурав.
- Инфляц зорилтот түвшнээс дээгүүр өссөөр байна.
- Төсвийн шинжтэй ба төсвийн бодлого хэт сул хэвээр байна.
- Ковидын эсрэг хуулийг 2022 оны эцэс хүртэл сунгаснаар Монголбанкны бие даасан байдлыг алдагдуулж төсвийн шинжтэй санхүүжилт руу түлхсэн хэвээр байна.
- Хэдий ийм төсвийн гүйцэтгэл төлөвлөснөөс сайжирч буй ч эрдсийн бус үндсэн тэнцэл ихээхэн алдагдалтай хэвээр, ХО-ын хойшлуулсан зардлууд импортыг нэмэгдүүлэх, ханш сулруулах, инфляц нэмэгдүүлэх үр дагавруудтай байна.
- Дотоодын хувийн секторын сул идэвхжил өндөр инфляц, зээлийн нөхцөлүүд олдоч зэргээс болж нэмэгдэхгүй байна.
- 2023 оны эцэс хүртэл инфляц өндөр түвшинд байж зорилтот түвшинд очихооргүй байна.
- Урсгал дансны алдагдал сорилт байсан хэвээр, ГВУН хангалттай түвшинд хүрэхээргүй, 2023-2024 онд гадаад бондын төлбөр, гадаад өрийн дарамт том сорилт хэвээр байна.
- Гадаад санхүүгийн нөхцөлүүд муудаж түүхий эдийн үнэ хэлбэлзэл ихтэй байна.
- Монголын банкуудын корреспондент харилцааг US, UK хэдий хүчтэй дэмжиж буй ч Оросын эсрэг авч буй хориг арга хэмжээний үр дагавруудаас болж эрсдэлд орох боломжтой
- 2024 оны сонгуулийн өмнөх төсвийн тэлсэн бодлого, санхүүгийн болон ТӨҮГ-дын алдагдал
- Эдийн засгийн өсөлтийг хангах бодлого гол нь уул уурхайн эдийн засагт анхаарч, уул уурхайн бус эдийн засгийн өсөлтийг хангах бодлого төлөвлөж хэрэгжүүлээгүй.
- ГВУН-ийг эзэмшиж удирдах, валютын ханшийн менежментийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх төрлийн мэдээллийг бүрэн авах боломжийг Монголбанкинд олгоогүйн улмаас ЭТТ, Эрдэнэт ГОК зэрэг валютын нөөц бүрдүүлэгч нэгжүүдийн экспортын гэрээнүүд, тэдгээрийн шуурхай анхдагч статистик мэдээлэл иж бүрэн биш, тодорхой зохицуулалтгүй хэвээр байна.

Errors

- Бодлогын зохицуулалтаа эдийн засгийн гадаад дотоод орчин, тэнцвэр алдагдах тохируулах хугацаа алдсан.
- Монголбанкны үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг алдагдуулж төсвийн шинжтэй санхүүжилт хийхэд хүргэсэн.
- Хил дээрх саад бэрхшээлүүдийг арилгах, барааны урсгалыг зохицуулах үйл ажиллагаа нэгдсэн удирдлага, уялдаа холбоо байхгүйгээс болж цаг алдсан, эдийн засгийн сэргэлтэд нөлөөлсөн.
- Оффтек бартер гэрээнүүд валютын нөөц нэмэгдүүлэх, ханшийн дарамтыг сулруулахад сөрөг нөлөөлж, импортыг нэмэгдүүлсэн.
- Төсвийн алдагдал, тэлсэн бодлого, засгийн газрын гадаад өрийн удирдлага хоорондоо холбоогүй.
- Төсвийн шинжтэй үйл ажиллагаа, сонгуулийн орчин дагасан, төсвийн тэлсэн бодлого хэрэгжүүлсэн.
- Монголбанкныг үндсэн зорилтоос ил холдуулсан эрх зүйн болон бодлогын шахалт үүссэн нь инфляцын зорилтот түвшнээс давсан үнийн ерөнхий өсөлтийг бий болгож, эдийн засгийн дотоод тэнцвэрийг алдагдуулсан.
- Уул уурхайн бус төсвийн үндсэн алдагдлыг багасгах бодлого байхгүй.
- Төсвийн тэлсэн бодлого баталж хэрэгжүүлэхдээ импорт эрс нэмэгдэх түлхэц болох цаашлаад валютын ханш, инфляцад дарамт үзүүлэх зэргийг тооцоогүй.
- ГВУН-ийг эзэмшиж удирдахад шаардлагатай бүх төрлийн мэдээллийг бүрэн бөгөөд шуурхай авч байх боломжийг Монголбанкинд хуулиар болон де-факто олгоогүйн улмаас валютын нөөц бүрдүүлэгч гол ТӨҮГ-уудад валютын удирдлага ил тод бус, нууцын зэрэглэлд орж, тэдгээр нэгжийн экспортын гэрээнүүд, тэдгээрийн гүйцэтгэл хяналтгүй явагдаж, оффтек бартерын гэрээнүүд байгуулсан валютын урсгал болон түүний бүртгэл, хяналтын тогтолцоо алдагдсан.

Rationales

- Эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэр алдагдах эрсдэлийг урьдчилан харах, холбогдох бодлогын арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд ЗГ санаачлагч, манлайлагч байж чадахгүй байна.
- Монголбанкны бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх хууль эрх зүйн өөрчлөлтийг 2023 онд багтаан хийх, төсвийн давамгайлал, төсвийн алдагдлыг эрс бууруулах, ТӨҮГ-ууд, ялангуяа Эрдэнэт ГОК-ын ил тод байдлыг хангах, экспорт, импортын гэрээнүүдийг ил болгох, ТӨҮГ-уудын валютын орлого, зарлагыг Монголбанк хянадаг болгох
- Валютын интервенц хийж буй арга хэлбэрээ өөрчлөх, “leaning against the wind” зарчмыг тууштай хэрэгжүүлэх, УИХ-аас “ханшийг тогтворжуулах” шууд болон шууд бус дарамт үзүүлдгийг зогсоох
- Төсвийн тэлсэн бодлого, нийт алдагдал түүний дотор уул уурхайн бус үндсэн алдагдлыг багасгах бодлого хэрэгжүүлэх, ЗГ-ын гадаад өрийн удирдлагыг зөвхөн Сангийн яам хэрэгжүүлж буйг өөрчилж multisectoral, stakeholders based зарчмаар боловсронгуй болгож хагас жил тутам ҮАБЗ-ийн түвшинд хэлэлцдэг болох
- 2024-2025 оны төсвийн төсөөлөл, төлөвлөлтийг өөрчилж алдагдлаа ДНБ-ий 1 хувиас хэтрүүлэхгүй байх, “сонгуулийн цикл сөрсөн” өсөлтийн хүртээмж, тогтвортой байдлыг хангах зорилттой байх, төсвийн тогтвортой байдалд хяналт тавих институцийг жинхэнэ бие даасан, хараат бус статустай болгох эрх зүйн өөрчлөлт хийх
- 2022 оны ДНБ-ий өсөлт төсөөллөөс давж 4.8% болсон ч нийт нийлүүлэлтийн тал дээр өсөлт эмзэг хэвээр байна. Ихэнх секторын өсөлтөд оруулсан хувь нэмэр маш бага хэвээр, ХАА, бөөний ба жижиглэн худалдаа, БЦТ өсөлтийн гол хувь нэмрийг эцсийн хэрэглээ, МЭХҮЗӨ хангасан байна. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтын хувь нэмэр бараг байхгүй, бараа материал, бэлэн бүтээгдэхүүний л нөөц гол хувь нэмрийг оруулсан байна. Цэвэр экспорт -7.8% , МЭХҮЗӨ +3586.2 тэрбум төгрөг байна.
- Гадаад худалдааны нэрлэсэн тэнцэл 3836.0 сая доллар болсон ч бодит тэнцэл нь 1571,5 сая доллар байна. Гадаад худалдааны нөхцөлийн индекс -28,2% болж муудсан, үүний дотор экспортын үнийн индекс -22.9%, эрдэс бүтээгдэхүүний экспортын үнэ -32.1% буурсан ба 2023 онд үргэлжлэхээр байна (ерөнхий хандлага).
- Импортын үнийн индекс өмнөх оноос эрс нэмэгдэж 107.6% болсон.
- 2022 онд үйлдвэрлэгчийн үнийн индекс 20.3%, худалдааны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс 26.8% нэмэгдсэн, хэрэглээний үнийн индекс 2 оронтой тоонд, ДНБ-ийн дефлятор 15.8%, ӨЭХЗ-ын дефлятор 9.7% байгаа нь 2023 онд инфляцыг 1 оронтой тоонд хүргэх зорилт биелэгдэхгүйд хүргэхээр байна. ДНБ-ий төсөөлөл 5%-иас 7-8%, бүр 8-9% хүрч өсөх боломжтой. Энэ өсөлтөд нийт нийлүүлэлтийн талд уул уурхайн үйлдвэрлэлийн бодит тоо хэмжээний өсөлт, нийт эрэлтийн талд хөрөнгө оруулалтын идэвхжил нэмэгдэх нь гол хүчин зүйл болох төлөвтэй байна.
- Ийм орчинд мөнгөний бодлогын төлөвийг цаашид хатууралгүйгээр тогтвортой хадгалах, эдийн засгийн тухайн үеийн байдлыг харгалзан багахан нэгжээр бууруулж эдийн засгийн идэвхжилийг хангах, мөнгөний нийлүүлэлтийг харьцангуй доогуур, жигд өсгөх бодлогыг хэрэгжүүлэх, энэхүү бодлогыг хэрэгжүүлэх төсвийн орчныг бүрдүүлэх нь чухал байх болно.
- Уул уурхайн бус эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх сэдэл дээр суурилсан бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх нь ЗГ-ын дунд хугацааны тэргүүлчлэлийн бодлого байвал зохих бөгөөд Монголбанкны хувьд ийм бодлогод тохирсон мөнгө, санхүүгийн орчныг үүсгэх шаардлагатай.
- Монголбанкийг үндсэн зорилтоос нь де-факто холдуулсан эрх зүйн болон бодлогын шахалтыг арилгаж, зорилтын түвшнээс давчихсан байгаа 2 оронтой инфляцыг 2023 онд зорилтот түвшнээс хэт хол биш түвшинд оруулах хүчин чармайлтыг ЗГ нийлүүлэлтийн гаралтай хүчин зүйлүүдийн саад бэрхшээлийг арилгах төдийгүй төсвийн болон өрийн тогтвортой байдлыг хангах, ГВУН-ийг нэмэгдүүлэх дунд хугацааны зорилтот хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх, импортын эрэлтийг хөөрөгдөхгүй байх тоо хэмжээний болон үнийн өсөлтийг зохистой удирдах бодлого хэрэгжүүлэх замаар дэмжих шаардлагатай.
- ГШХО-ыг дэмжих эрх зүйн болон институцийн орчныг сайжруулах чиглэлээр ОУСКорпорацаас гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх, бизнесийн орчлын реформыг тууштай үргэлжлүүлэн өрсөлдөх чадварыг түвшнийг дээшлүүлэх нь чухал.

Эх сурвалж: Судлаачийн хийсэн тойм



МОНГОЛБАНКНААС ШИНЭЧЛЭН БАТАЛСАН, НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН ЖУРАМ



Захиргааны хэм,
хэмжээний актын
баталсан огноо
болон бүртгэлийн
дугаар

2023.01.19



2023.01.31
6141

2023.01.25



2023.02.09
6151

2023.01.25



2023.02.13

2023.04.03



2023.04.17
6207



№	Захиргааны хэм, хэмжээний актын нэр	Хуулийн үндэслэл	Голлох өөрчлөлт
1	Банкийг албадан татан буулгах арга хэмжээг хэрэгжүүлэх, банкны эрх хүлээн авагч томилох, дуусгавар болгох журам	Төв банк /Монголбанк/-ны тухай хууль ¹ , Банкны тухай хууль ²	- Банкны эрх хүлээн авагчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлсэн - Банкны эрх хүлээн авагчаар ажиллах бүрэн эрхийн хугацааг заасан - Банкны хөрөнгийг худалдан борлуулах зарчмыг тусгасан - Өр, төлбөрийг төгрөгт хөрвүүлэн баталгаажуулах
2	Банкийг тогтворжуулах төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжүүлэх журам	Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, Банкны тухай хууль	- Банк Монголбанкнаас олгох төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зээлээс бусад хөнгөлөлт, дэмжлэгийг төлөвлөгөөнд тусгахгүй байхаар заасан - Банк тогтворжуулах арга хэмжээг үнэлэхэд үр дүнгийн үнэлгээ, хэрэгжихүйц байдлын үнэлгээг ашиглахаар заасан - Төлөвлөгөөг баталж, боловсруулж Монголбанканд мэдэгдэх, шаардлага хангасан эсхийг үнэлэх
3	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмын нэмэлт, өөрчлөлт	Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль ³	- Эрсдэлийн хүчин зүйлсэд "ВХҮҮ-ийн хувьд зохицуулалтгүй ВХҮҮ, бүртгэлгүй хэтэвч (unhosted wallet), хар жагсаалт"-д багтсан хэтэвчнээс хийгдсэн гүйлгээг нэмсэн - ВХҮҮ нь харилцагчийг таньж мэдэх болон эцсийн өмчлөгчийг таньж мэдэх, хянах, баталгаажуулах арга хэлбэр болон үүрэг нэмэгдсэн - ВХҮҮ корреспондент, хамтрагч (counterparty), дундын (intermediary) ВХҮҮ-д үйлчилгээ үзүүлэхэд авах арга хэмжээг нэмсэн. Журамд орсон нэмэлтийг 2023.07.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө.
4	Сэндбокс зохицуулалтын орчны журам	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль ⁴ , Монгол Улсын засгийн газрын тухай хууль ⁵ , Төв банк /Монголбанк/-ны тухай хууль	- Сэндбокс орчинд туршигдах бүтээгдэхүүн, үйлчилгээг тусгайлан заасан - Сэндбоксыг хариуцан ажиллах чиг үүрэг бүхий албаны чиг үүргийг тусгасан - Бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөс хамааран сэндбоксоод орох, туршигдах хугацаа сунгагдах, сэндбоксоос гаргах зэрэг шийдвэрийг Монголбанк эсхүл Санхүүгийн зохицуулах хороо гаргахаар өөрчилсөн

Журмыг хэрэгжүүлэх байгууллага



Монгол улсын хэмжээнд 12 арилжааны банк, 1 хөжглийн банк хуулийн дагуу Монголбанкны зөвшөөрөлтэйгөөр банкны үйл ажиллагаа эрхэлж байна.



Сэндбокс зохицуулалтын орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ туршиж буй 4 хуулийн этгээд байна.

Хүлээгдэж буй үр дүн

2023 оны 1-р улиралд батлагдсан захиргааны хэм, хэмжээний хүлээгдэж буй үр дүн:

- Банкны эрсдлийг удирдах тогтолцоо бэхжих
- Банк тогтворжуулах арга хэмжээг үр дүн, хэрэгжихүйц байдлыг үнэлэх
- Эрсдэлд суурилсан хяналтын шалгалтад шилжих
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь харилцагчийг таньж мэдэх
- Шинэ технологийг эрсдэл багатайгаар, хэрэгжихэд бэлэн байдлаар санхүүгийн зах зээлд нэвтрүүлэх





Л.ОЮУН: МОНГОЛЧУУДЫН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫН ГОЛ ХҮНДРЭЛ НЬ ТӨЛӨВЛӨЛТ

Өрхийн санхүүгийн боловсролын асуудлаар БШУЯ-ны харьяа Боловсролын мэдээллийн технологийн төвийн дэргэдэх Цахим сургуулийн зөвлөх, Шинжлэх ухааны доктор Л.Оюунтай ярилцлаа.

Монгол Улсын иргэдийн санхүүгийн боловсролын тогтолцооны онол арга зүй сэдвээр та Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан. Санхүүгийн боловсролын тогтолцоо манайд хэр байна вэ?

Санхүүгийн боловсрол олгох тогтолцоо манайд байна. Санхүүгийн боловсрол олгох хөтөлбөр, сурах бичиг, багшийн ном бүгд байна. Доголдсон хэсэг ч байна. Санхүүгийн боловсрол олгох багшийг бэлтгэх хэрэгтэй. Одооноос бид нийгмийн ухааны багш нараа бизнес судлал заах бэлтгэлийг хангаж байна.

Манайд банк, санхүүгийн байгууллагад хадгаламж хуримтлал үүсгээрэй, эзэл аваарай, орлогоо нэмэгдүүлээрэй гэж сурталчилгаа их явдаг. Гэтэл иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшин харилцан адилгүй байна. Тиймээс түвшин түвшинд нь сургах багш шаардлагатай юу?

Санхүүгийн байгууллагууд санхүүгийн зуучлагч байдаг. Тэдний зээл, хадгаламж, төлбөр тооцоо зэрэг үйлчилгээ нь хүмүүсийг мөнгөө удирдахад нь бүтээгдэхүүнийхээ нөхцөлөөр дамжуулж тусалдаг. Санхүүгийн байгууллагуудын бүтээгдэхүүний мэдээллийг аваад, өөрийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлээд сонгох чадвар, мэдлэгийг санхүүгийн боловсрол гэдэг. Тиймээс бидний олгох гээд байгаа мэдлэг, чадвар санхүүгийн байгууллагуудтай салшгүй холбоотой.

Иргэдэд санхүүгийн мэдлэг шаардлагатай, өрхийн төсвөө удирдах хэрэгтэй гэдэг. Ер нь өрхийн төсөв гэж юу вэ?

Төсөв гэж ярихаар хүмүүс өөрт хамааралгүй юм шиг ханддаг. Гэтэл энэ нь хувь хүнд, өрхөд хамаатай. Зарим хүн улсад л зөвхөн төсөв байдаг гэсэн ойлголттой явдаг. Өрхийн төсвөө анзаардаггүй. Ер нь төсөв хувь хүнд ч, албан байгууллагад ч, өрхөд ч бий. Орлоготой,

зардал гаргадаг субъект болгон төсөвтэй. Манайхны өрхийн төсвийн удирдлага хангалтгүй байдаг. “Надад хамааралгүй” гэсэн хандлага нь өрхийн төсвийн удирдлага муу байгаагийн гол шалтгаан болдог. Зарим иргэн орлого, зарлагаа бүртгэдгээ “төсвөө удирдаж байна” гээд ойлгочихдог. Орлого, зарлагаа бүртгэнэ гэдэг анхны алхам. Цааш удирдах санхүүгийн боловсрол болж байгаа юм.

Иргэдийн санхүүгийн боловсролын талаарх судалгааны үр дүн хэрхэн гарч байна вэ?

-Нэг үеэ бодвол “мөнгийг удирдах хэрэгтэй, хуримтлуулах хэрэгтэй” гэдэг ойлголт хүмүүст хүрсэн. Гэхдээ үүнийг яаж удирдахаа тэр бүр мэдэхгүй байна. Иргэдийн санхүүгийн боловсролын талаарх судалгааг бид гаргасан. Хамгийн сүүлд 2019 онд санхүүгийн хямралд ороход ямар хүчин зүйл нөлөөлж байна вэ, өрхийн гишүүдийн боловсролын түвшин ямар байна

вэ зэрэгт судалгаа хийлээ. Эндээс харахад өрхийн гишүүдийн боловсролоос санхүүгийн боловсрол нь хамаарч байна. Ерөнхий боловсрол дүүргэсэн түвшнөөс эхлээд их, дээд сургууль төгссөн, үүн дотроо бакалавр, магистр, доктор гээд боловсролын түвшин ахих тусам мөнгөө удирдах мэдлэг, чадвар нь өндөр байгаа нь харагддаг. Өрхийн гишүүдийн нэг нь санхүүгийн боловсролын түвшин сайн байвал хямралд өртөх магадлал нь бага болдог. Санхүүгийн боловсролын түвшин буураад ирэхээр тухайн өрх төсөв удирдагдахгүй гэж үзээд зөнд нь хаяж байгаа харагддаг.

Манайхан ипотекийн, цалингийн, хэрэглээний, автомашины гээд төрөл бүрийн зээлтэй. Энэ бүх зээлээ төлж, барагдуулсан хүмүүс дараагийн зээлээ авахдаа санхүүгийн боловсролын түвшин дээшилсэн эсэх нь анзаарагддаг уу?

Тийм. Санхүүгийн боловсрол гэдэг эсэх нь мөнгөө удирдах мэдлэг. Зээлийг үйл ажиллагаагаа өргөжүүлэх, орлогоо, нэмэгдүүлэх нэг эх үүсвэр гэж ойлгосон хэсэг нь бий. Тэд зээл аваад, үйл ажиллагаагаа өргөжүүлээд, орлогоо нэмэгдүүлээд явдаг. Харин зээлийг өр гээд ойлгосон хэсэг нь дарамт гэж ойлгоод, орлого бүтээхгүй зүйлд зээл авч, тухайлбал хэрэглээндээ зарцуулснаас болоод зээл төлөх боломжгүй болдог. Энэ бол зээлд

хандах хандлага нь буруу бүлэг юм.

Монгол Улс хэзээ ч өртэй байгаагүй Телевизийн сурталчилгаа, цахимаар онлайн худалдаанаас төлөвлөгөөгүй бараа, бүтээгдэхүүнээ худалдан авах нь элбэг. Дараа дараагийн судалгаануудаас санхүүгийн мэдлэг сайжирч байна уу?

Улсын хэмжээнд банкны хадгаламжийн хэмжээ, хадгалуулагчийн тоо нэмэгдсэн. Энэ нь эерэг үзүүлэлт. Цар тахлын хоёр жилд хүмүүс банканд хадгаламж нээж, хадгалаад эхэлсэн. Амьдрал хүмүүсийг хадгаламжтай байх ёстойг ойлгуулсан гэж дүгнэж болно. Манайханд байдаг нэг дутагдал бол урьдчилж төлөвлөдөггүй, төлөвлөгөөгүй амьдардаг байдал. Төлөвлөгөө байсан ч богино хугацааг хамардаг. Төлөвлөгөө нь дараа долоо хоногийн, үсрээд л дараа сарын төлөвлөгөө байдаг. Ахиад хэлэхэд, монголчуудын санхүүгийн боловсролын гол хүндрэлтэй асуудал нь төлөвлөлт. Энэ нь Дэлхийн банкны судалгаагаар батлагдсан.

Банкны хадгаламжаас гадна иргэд гэнэтийн зүйлд хөрөнгө оруулах нь бий. Койн зэрэг гэнэт их мөнгөтэй болох зар, сурталчилгаанд бүх хөрөнгөө барьцаанд тавьж алдаж байна. Гэнэт баяжих гэсэн сэтгэлгээг яаж халах вэ?

Хөдөлмөр бол орлогын эх үүсвэр байх ёстой. Шударгаар

орлого олно гэхээсээ илүү “хурдан мөнгөтэй болох” гэдэг сэтгэлгээ давамгайлж байна. Энэ нь онохоосоо илүү алдахад хүргэдэг. Санхүүгийн боловсролын талаарх мэдлэг дутагдсанаас үүдэлтэй. Цаашдаа алдаануудаасаа сургамж авна гэж найдаж байна. Санхүүгийн боловсролын хичээл энэ оноос л ЕБС -ийн ахлах ангид орж эхэлсэн. Хүмүүс өмнө нь санхүүгийн мэдлэгийг бусдыг харж, амьдралаасаа суралцсан мэдлэгээрээ л зүтгэж байгаа. Энэ мэдлэг нь бат гүн сууж өгөөгүйгээс алдаад байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Улсын эдийн засаг хямрахад айл өрх дагаад хямардаг. Нийгмийг авч явдаг дундаж давхарга байхгүй боллоо гэдэг. Өнөөдөр манайд зөвхөн цалингаараа амьдралаа авч явах бололцоо бий юу?

Ер нь бол боломжгүй. Манай өрхийн төсвийн орлого наад захын хэрэгцээг хангах түвшинд байна. Нийт хадгаламж эзэмшигчдийн таван хувь нь нийт хадгалмжийн 70 хувийг эзэмшдэг гэсэн статистик тоо бий. Хадгаламж эзэмшиж байгаа хүмүүсийн 95 хувь нь нийт хадгаламжийн 30 хувийг эзэлж байна. Энэ тоо юу хэлж байна вэ гэхээр бидний ихэнхэд орлогоороо хэрэгцээгээ хангаад явах боломж сул байгааг харуулж байгаа юм. Зах зээлийн эдийн засгийн тогтолцооны онцлог бол хувь хүнээс

амьдралын их зүйл хамаардаг нийгэм. Мэдлэгээ дээшлүүлнэ, төрөл бүрийн ажил эрхэлж болно.

Өр, зээл хоёр ялгаатай. Өргүй амьдрах сэтгэлгээ манайд хэр давамгайлдаг бол?

Өр, зээлийн ялгааг сайн мэдэхгүй байна. Энэ нь олон зүйл дээр харагддаг. Жишээлбэл, “Зээл авч өрөнд ороод яах вэ?” гэдэг. Зээлээ өр гээд ойлгочихсон. “Би өртэй” гээд түүндээ их гутардаг. Зээл бол орлогын нэг хэлбэр. Өр бол хугацаандаа төлж чадаагүй зээл. Үүнийг ойлгуулахын тулд сургалт явуулахдаа эхлээд “Өртэй хүн байна уу” гэж асуухаар, оролцогчид бүгд гараа өргөдөг. Хичээлээ орж, өр, зээлийг тайлбарлаад, дараа нь дээрх асуултаа дахин тавихад бүгдээрээ “өр биш зээлтэй” байдаг.

Монгол Улс хэзээ ч өртэй байгаагүй. Гэтэл “Монгол Улсын өр тэдэн тэрбум ам.доллар боллоо” гээд тархи угаадаг. Манай улс олон улсаас авсан зээлийнхээ төлөх хугацааг нэг ч хоног хоцроож байгаагүй. Яг хугацаанд нь төлдөг байсан тул энэ бол өр биш зээл юм. Ялгааг нь мэдэж авахаар хандлага нь өөрчлөгддөг.

Тиймээс иргэдэд санхүүгийн боловсролыг олгох, соён гэгээрүүлэх ажил хэрэгтэй байна гэдэг нь эндээс харагддаг. Иргэд ипотекийн зээлээр сайхан орон сууц аваад амьдарч байна.

Харин мөнгөө хадгалаад тэр хэмжээний байртай болох боломж байхгүй. Гэтэл банк, санхүүгийн байгууллага зээл ав, байртай бол гэж байгаа нь сайхан үйлс болохоос өр гэдэг дарамтны асуудал биш.

Манайхан мөнгөө юунд илүү зарцуулж байна вэ?

Манайхны зардал төрлийн хувьд их явцуу. Хүмүүсийн зардлын төрөл нь амьжиргааны наад захын хэрэгцээг хангадаг хоол хүнс, хувцас хунарт байдаг. Зардлын төрөл нь баялаг. Тухайлбал, оюун ухаанаа тэлж, мэдлэгээ өргөжүүлэх сургалтад зардал гаргаж байх ёстой. Энэ зардлууд нь ирээдүйн орлого олох зардал юм. Ер нь бол зардал гаргаж байж орлого олдог. Урлаг, спорт, аялал, зугаалгад зардал гаргах хэрэгтэй. Энэ бүхнээсээ энерги авч, өөрийгөө хөгжүүлж, хөгжсөний хэрээр орлого нэмэгдэж байдаг нь зүй ёсных юм даа. Тиймээс зарлагын төрөл манайд үнэхээр ядмаг шүү. Зөвхөн амьд байх хэмжээнд л зарлага гаргаж байна. Оролдлого хийгээгүй байж орлогоо голж болохгүй.

Тэгвэл иргэдийг мөнгөө хуримтлуулах, зээлээ хугацаанд нь төлөх талаар ямар зөвлөгөө өгөх вэ?

Тоо маш их зүйл хэлж өгдөг. Хүн тоо харах ёстой. Санхүүгийн асуудалд бүдүүн баримжаагаар хандах хэрэггүй. Орлоготой, хэдэн төгрөг олж байгаагаа мэддэггүй, хаанаас хэдэн төгрөг

орж ирж байгаагаа ч мэддэггүй тохиолдол харьцангуй их. Орсон орлогоо юунд илүү зарцуулдгаа ч мэддэггүй. Ямар ч өгөдөлгүй, тооны үнэлгээгүй явахаар шийдвэр гаргаж чаддаггүй. Тиймээс орлого, зардал хоёроо бүртгэж, бичих хэрэгтэй. Бичихээд дэвтрээ хааж бас болохгүй.

Ганц, хоёр минут харж, суу. Ингэснээр хэдий хэмжээний орлого орж ирсэн байна, юунд зарцуулсан байна вэ гэдгээ хүн тунгаан, шүүдэг. Тиймээс л орлого, зардлаа бичээрэй. Ингэж тэмдэглэж, бүртгэснээр тогтмол ордог орлогоо болон тохиолдолоор буюу тогтмол бус орлогоо мэдэж авдаг. Зардал мөн адилхан. Бичээд, бүртгээд эхлэхээр мөнгөө хэрэггүй, шаардлагагүй зүйлд зарцуулахаа больж, мөнгөө / зардлаа / удирдаад эхэлдэг. Энэ нь явцдаа амьдралын хэвшил болно. Орлого, зардлаа бичдэг хүмүүс зардлаа хэмнэж, орлогоо нэмэгдүүлж, амьдралаа сайжруулж болдог.

Үндсэн цалингаас гадна орлогоо нэмэгдүүлэх талаар яаж тооцох хэрэгтэй вэ?

Нэгдүгээрт, эрхэлсэн ажил, мэргэжилдээ мэргэшсэн, өндөр түвшинд байх хэрэгтэй. Энэ бүхнээрээ албан тушаал дэвшиж, цалингаа нэмэгдүүлнэ. Ингэснээр өөрийгөө хөгжүүлэх боломж нээгддэг. Хэрвээ тухайн албан байгууллага таныг үнэлэхгүй байвал дараагийн байгууллага

өөрийг чинь дуудаад, тосоод авна. Ингээд дараа, дараагийн боломж аяндаа гарч ирдэг. Хоббигоо хөгжүүлж бизнес хийснээр нэмэгдэл орлоготой болох боломжтой.

Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр ямар арга хэмжээ зохион байгуулж байна?

БШУЯ-ны харьяа Боловсролын мэдээлэл, технологийн төвийн дэргэдэх Цахим сургуульд би ажиллаж байна. Энэ Цахим сургууль ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад Бизнес судлалын хичээл заадаг. Аравдугаар ангид Хувь хүний санхүү, 11 дүгээр ангид Өрхийн санхүү, 12 дугаар ангид Бизнесийн санхүүгийн хичээл ордог. Ингэснээр бид санхүүгийн боловсролтой иргэн бэлтгэж байна. Энэ утгаараа иргэдийн санхүүгийн боловсролд ахиц гарна гэж харж байгаа юм. Хувь хүмүүсийн тухайд ямар зүйл уншсан, судалсан, суралцсан гэдэг утгаараа санхүүгийн мэдлэг нь дээшилж байна. Өнөөдөр орлогоо нэмэгдүүлэх орчин бүрдсэн, боломж нь ч нээлттэй байгаа. Тиймээс хүн мэрийж, хичээх хэрэгтэй.

Орлого багатай хүмүүст хадгаламж, хуримтлал яриад яах вэ гэж шүүмжилдэг. Орлого л олж байгаа бол тодорхой хэмжээний хэмнэлт хийж, хадгалж болдог юм. Энэ хэрээр хадгаламж нь нэмэгдэн, өргөжиж, өөртөө

урамшиж байдаг. Хүмүүс хадалгамж үүсгэн, орлогоо өсгөхөөр оролдож байгаа. Гэхдээ удаан байна.

"Хүүхдийн 100 мянган төгрөгийг хүүхдэд нь өг"

Та Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад бизнес судлалын хичээл зааж байна гэлээ. Хүүхдүүдийг санхүүгийн боловсролтой болгоход гэр бүлийн нөхцөлд хэрхэн сургах вэ?

-Санхүүгийн боловсролын хичээлийг заахаар хүүхдүүд хүлээн авч, өөрчлөгдөж байгаа нь харагдаж байна. Хүүхдүүдийг амьдралд бэлтгэх хэрэгтэй. Өрхийн төсөвт оролцуулаад, орлого, зардлаа тэдэнтэй хамт сууж байгаад ярилцах хэрэгтэй. Том болж байгаа хүүхдээрээ өрхийн төсвөө удирдуулж, болно. Өрхийн сарын зардлаа хүүхдүүддээ хариуцуулж болно. Ингэхээр тухайн хүүхэд хариуцлага үүрээд тунгааж эхэлнэ. Би хүүхдийн мөнгө болох 100 мянган төгрөгийг хүүхдэд нь өг гэж зөвлөдөг.


Учир нь тэр хүүхэд 100 мянган төгрөгөөрөө сарын хэрэглээгээ хангаж, санхүүгийн мэдлэгээ нэмэгдүүлнэ. Хүүхэд тухайн сардаа мөнгөө хүргэнэ, дутаана, мөнгөгүй явна гээд маш том сургууль болно. Дараагийн сард орж ирэх мөнгөө анхааралтай зарцуулна. Харин хадгаламжинд хадгалахаар тэр мөнгө нь хүүхдийн мөнгө биш болно. Сангийн сайд Б.Жавхлан

"Хүүхдийн 100 мянган төгрөгийн ихэнхийг нь битгий хадгалаарай, хагасыг нь болов хүүхдээр зарцуулаарай" гэж хэлсэнтэй санал нэгддэг.

Санхүүгийн боловсрол хөтөлбөрт яаж хамрагдах вэ?

Цахимаар уу, танхимаар хичээллэх үү гэдгээ хүүхэд сонгоно. Аль ч аймаг, сумын хүүхэд цахимын нэг ангид орж хичээллэж байна. Гадаадад байгаа хүүхдүүд цахимаар хичээллэж байна. ЕБС-ийн ахлах ангийн 16 сонгон судлах хичээлийн нэг нь санхүүгийн боловсрол олгодог "Бизнес судлал" хичээл юм. Хөтөлбөр, ном гараад, багш бэлтгээд, эхний алхмаа хийлээ. Энэ хичээлийг цахимаар 700 гаруй, танхимаар 5-6 мянган хүүхэд сонгосон. Есдүгээр сарын нэгэнд анх хичээл ороход орлого, зарлагыг нь бичүүлж эхэлсэн. Одоо хүүхдүүд хадгалаад, хуримтлал үүсгээд өөрчлөгдөж байна.

ДУРСГАЛЫН *Зоос*



Нэр: Чингис хаан 1 унц
Зоос №
Он: 2002
Металл: Алтан зоос
Жин: 31.1 грамм
Диаметр: 38.61мм
Үнэ: 7,700,000₮
Сорьц: 9999
Цуврал: Монголын хаад



ФАТФ-ААС ЗӨВЛӨМЖ 24-ИЙГ ШИНЭЧИЛЖ, ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙГ ТОДОРХОЙЛОХ ТУХАЙ ШИНЭЧИЛСЭН АРГАЧЛАЛЫГ НИЙТЛЭВ


Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) техник хэрэгжилтийн 40 зөвлөмж нь улс орнуудын МУТСТ тогтолцоог бэхжүүлэхэд шаардлагатай бодлогын түвшний өөрчлөлтүүдийг тусгасан байдаг. Зөвлөмжүүд нь цаг үеийн нөхцөл байдал, технологийн ахиц дэвшилтэй холбогдуулан шинэчлэгдэж байдаг. Тухайлбал, ФАТФ-аас Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн ил тод байдлын тухай "Зөвлөмж 24"-д тусах шинэчлэлтүүдийг 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн чуулга уулзалтаар баталж, улмаар 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр эцсийн өмчлөгчийг үнэн зөв тодорхойлох тухай дэлгэрэнгүй аргачлалыг эцэслэн нийтэллээ.

ФАТФ-ЫН ЗӨВЛӨМЖ 24 (шинэчлэгдсэн)

Улс орнууд нь хуулийн этгээдийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд урвуулан ашиглах эрсдэлийг үнэлж, зохих урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах хэрэгтэй. Улс орнууд хуулийн этгээдийн эцсийн өмчлөлийн талаар хангалттай, үнэн зөв, хамгийн сүүлийн үеийн мэдээлэлтэй байх ёстой. Эрх бүхий байгууллага нь мэдээллийг эцсийн өмчлөлийн бүртгэл эсвэл өөр арга хэрэгслээр дамжуулан түргэн шуурхай, үр дүнтэй олж авах боломжтой байх хэрэгтэй. Улс орнууд хуулийн этгээдэд шинээр шилжих үнэт цаас гаргахыг хориглох бөгөөд нэгэнт олгогдсон шилжих үнэт цаасны хувьд баталгааг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ёстой. Улс орнууд "nominee" хувьцаа эзэмшигчид болон захирлуудыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зорилгоор урвуулан ашиглагдахгүй байх талаар үр дүнтэй арга хэмжээ авах ёстой. Улс орнууд зөвлөмж 10, 22-т заасан шаардлагуудыг биелүүлж ажиллах санхүүгийн байгууллагууд болон СББМҮҮ-д эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэлд нэвтрэх боломжийг бүрдүүлэх асуудлыг авч үзэх хэрэгтэй.

Шинэчлэгдсэн зөвлөмжийн тухай:

Шинэчлэгдсэн зөвлөмжийн дагуу улс орнууд эцсийн өмчлөгчдийг тодорхойлоход ашиглагддаг мэдээллийн санд төрийн холбогдох байгууллагууд түргэн шуурхай хандах тогтолцоог бүрдүүлэх, харилцагчдын эцсийн өмчлөгчийн мэдээллийг үнэн зөв байлгаж, түргэн шуурхай хандах боломжтой байх шаардлагатай. Мөн улс орнуудыг эцсийн өмчлөгчийн тухай мэдээллийн санг холбогдох улсын бүртгэлийн байгууллагад хариуцуулах эсвэл илүү үр дүнтэй механизмыг бий болгохоор заасан байна. Түүнчлэн эцсийн өмчлөгчийг үнэн зөв тодорхойлоход шаардагдах бусад нэмэлт арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр зөвлөмжид тусгажээ.





Шинэчлэгдсэн аргачлалын тухай:

ФАТФ-аас хувийн хэвшлийнхэн болон оролцогч талуудтай хэдэн сарын турш эрчимтэй зөвлөлдсөний үр дүнд шинэчлэгдсэн аргачлалд төр, хувийн хэвшлийн оролцогч талуудад тулгамдаж буй асуулт, асуудлыг тодорхой, ойлгомжтой болгохыг зорьсон байна. Аргачлал нь авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний хэрэгжилтийг хөнгөвчлөх зорилготой бөгөөд ингэснээр халхавч компаниуд гэмт хэрэг, терроризмтой холбоотой хууль бусаар орлого олох аюулгүй газар байх боломжгүй болох юм.

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс “Эцсийн өмчлөгчийн тухай” цахим семинарыг 2023 оны 3 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулж, ФАТФ-ын Зөвлөмж 24-т оруулсан өөрчлөлт, шинээр гаргасан гарын авлагын талаар танилцуулснаас гадна Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс, Тайвань, Шинэ Зеланд, Канад, Малайз Улсууд өөрсдийн туршлагыг хуваалцав. Уг цахим семинарт Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Тагнуулын Ерөнхий газар, Санхүүгийн зохицуулах хорооны албан тушаалтнууд хамрагдсан юм.



Монгол Улсын Зөвлөмж 24-ийн техник хэрэгжилтийн үнэлгээ:



Монгол Улс нь ФАТФ-ын Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 2019 оны 2 дахь шатны Явцын тайланд Зөвлөмж 24-ийн үнэлгээг Дийлэнхийг биелүүлсэн болгож ахиулсан ба тус бүлгээс Монгол Улсын дараах хүчин зүйлсийг харгалзан үнэлгээг ахиулж байв. Үүнд:

- Харилцан үнэлгээнээс хойш Монгол Улс хуулийн этгээдийн үйл ажиллагааг харгалзан хэд хэдэн салбарын эрсдэлийн үнэлгээг хийсэн боловч хуулийн этгээдийн төрлөөр нь ялгаж эрсдэлийг үнэлээгүй байна. Эдгээр эрсдэлийн үнэлгээ нь үйл ажиллагааны төрлөөс хамаарсан тодорхой төрлийн хуулийн этгээдийн хувьд үүсч болох зарим эрсдэлийг ойлгоход тусалж болох шалгуурт заасан шаардлагыг биелүүлээгүй хэвээр байна.
- Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ)-т ирүүлсэн мэдээллийн үнэн зөв эсэхийг шалгах тогтолцоо хэрэгжиж байна. Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан нь дараах үүргийг хэрэгжүүлэхэд томоохон ач холбогдол үзүүлсэн. Үүнд:
 1. Хуулийн этгээдийг бүртгэх эсвэл одоо байгаа хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулахдаа үнэн, бодит зөв мэдээллийг УБЕГ-т ирүүлэх үйл ажиллагаа (14.4.-р Зүйл);
 2. УБЕГ-д ирүүлсэн мэдээллийн үнэн зөв, бодит эсэхийг шалгаж, баталгаажуулах (16.1.7, 19.4.1-р зүйл) бөгөөд мэдээллийн санд бүртгэх үйл ажиллагаа (11.1, 11.2-р зүйл).
- Хуулийн этгээд нь УБЕГ-т бүртгүүлэхдээ эцсийн өмчлөгчийг тодорхойлох талаар МУТС хуульд заасан хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авна. Энэ зөрчилд ногдуулах арга хэмжээ нь Монголын эдийн засгийн хувьд зөрчилтэй нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн байна гэж дүгнэжээ.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

Монгол Улсын төр, хувийн хэвшлийн байгууллагууд нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр баталсан Мөнгө угаахтай тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу цаашид эцсийн өмчлөгчийн мэдээллийн үнэн зөв байдлыг тодорхойлох ажиллагааг сайжруулахаар тогтмол хамтран ажиллаж байна.

ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ (АМ. ДОЛЛАРААР, 25/IV ӨДРИЙН БАЙДЛААР)



ИНФЛЯЦЫГ ТОГТВОРЖУУЛСНААР ХҮҮГИЙН ТҮВШИН ЦАР ТАХЛЫН ӨМНӨХ ТҮВШИН РҮҮ БУЦАХ БОЛОМЖТОЙ

Сүүлийн үед инфляцын өсөлттэй уялдуулан мөнгөний бодлого чангарснаар бодит хүү сөрөг түвшиндээ хэдий ч, түүхэн доод утгаасаа өсөх хандлагатай байна. Энэ өсөлт түр зуурынх уу эсвэл бүтцийн хүчин зүйлийг хэсэгчлэн тусгаж байна уу гэдэг нь бодлого боловсруулагчдын хувьд чухал асуулт юм.


1980-аад оны дунд үеэс хойш ихэнх өндөр хөгжилтэй орнуудын бодит хүүгийн түвшин бүх хугацаанд буурсаар байна. Бодит ханш ийнхүү урт хугацаанд өөрчлөлттэй байгаа нь хэвийн хүүгийн бууралтын дохио байх магадлалтай. Тэнцвэрт хүүгийн түвшин

гэдэг нь инфляцийг зорилтот түвшинд, эдийн засгийг тэлэлтгүй, агшилтгүй бүрэн ажил эрхлэлттэй байлгах бодит хүү юм.

Тэнцвэрт хүү нь мөнгөний бодлогын төлөвийг тодорхойлоход ашигладаг төв банкуудын жишиг юм. Мөн төсвийн бодлогод чухал ач холбогдолтой. Засгийн газрууд ихэвчлэн хэдэн арван жилийн хугацаанд өрөө төлдөг тул бодит хүүгийн урт хугацааны зангуу болох тэнцвэрт хүү нь зээлийн өртөг болон улсын өрийн тогтвортой байдлыг тодорхойлоход тусалдаг.

Хүүгийн түвшний түүхэн бууралт (богино хугацааны бодит хүү, %)

Өнөөг хүртэл ихэнх өндөр хөгжилтэй орнуудын бодит хүү тогтмол буурч байсан.



Sources: Federal Reserve Economic Data; and IMF staff calculations.
Note: The real interest rates are the difference between the three-month interbank rates and the average of the realized inflation measured by the consumption price index in the next three months for each country. Japan's 3-month interbank rates are spliced with certificates of deposit from 1979 to 2002.

IMF

ОУВС-ийн Дэлхийн Эдийн Засгийн Төлөв байдлын (World Economic Outlook) аналитик бүлэгт өнгөрсөн хугацаанд хэвийн хүүгийн өөрчлөлтөд ямар хүчин зүйл нөлөөлж байсан, өндөр хөгжилтэй болон хөгжиж буй зах зээлийн эдийн засагтай орнуудын бодит хүүгийн ирээдүйн хамгийн боломжит зам юу болохыг эдгээр хүчин зүйлсийн хэтийн төлөвт тулгуурлан судалсан байна.

Тэнцвэрт хүүгийн түүхэн хөшүүргүүд

Бодит хүүгийн өнгөрсөн үеийн бууралтад дүн шинжилгээ хийх чухал асуулт бол дотоод хүчин зүйлс эсвэл гадаад хүчин зүйлсийн аль нь илүү нөлөөлсөн бэ гэдэг асуудал юм. Жишээлбэл, Хятад болон дэлхийн бусад орнуудын бүтээмжийн өсөлт нь АНУ-ын бодит хүүнд чухал ач холбогдолтой юу?

Шинжилгээний үр дүнд гадаад хүчин зүйлс чухал боловч тэнцвэрт хүүгийн түвшинд үзүүлэх цэвэр нөлөө нь харьцангуй бага байсан байна. Хурдтай хөгжиж буй зах зээлийн эдийн засаг нь хөгжингүй орнуудын хуримтлалыг татах соронз болж, хөрөнгө оруулагчид гадаадад өндөр өгөөж хүртсэнээр тэнцвэрт хүүгийн түвшин өснө. Гэсэн хэдий ч хөгжиж буй зах зээл дээрх хадгаламж нь эдгээр орнуудын найдвартай, хөрвөх чадвартай хөрөнгөө хангах чадвараас илүү хурдан хуримтлагдах тул хөрөнгө оруулалтын ихэнх


хэсгийг АНУ-ын Төрийн сан зэрэг өндөр хөгжилтэй орнуудын засгийн газрын үнэт цаасанд дахин хөрөнгө оруулалт хийж, ингэснээр тэнцвэрт хүүг ялангуяа, 2008 оны дэлхийн санхүүгийн хямралаас хойш дахин бууруулжээ.

Энэ асуудлыг илүү гүнзгий судлахын тулд сүүлийн 40 жилийн тэнцвэрт хүүгийн хөдөлгөөнийг тайлбарлаж чадах бүтцийн нарийвчилсан загварыг ашиглая. Цэвэр хөрөнгийн урсгалд нөлөөлж буй гадаад хүчин зүйлсээс гадна нийт хүчин зүйлийн бүтээмжийн өсөлт (TFP буюу эдийн засгийн бүх хүчин зүйлийн орцыг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нийт хэмжээ) болон хүн ам зүйн хүчин зүйлүүд, тухайлбал төрөлтийн болон нас баралтын түвшин, тэтгэврийн хугацааны өөрчлөлт зэрэг нь тэнцвэрт хүүгийн бууралтын гол хөдөлгөгч хүч байгааг олж харах боломжтой.

Төсвийн санхүүжилтийн хэрэгцээ өндөр байгаа нь Япон, Бразил зэрэг зарим оронд бодит хүүг өсгөсөн. Тэгш бус байдал ихсэх, ажиллах хүчний эзлэх хувь буурах зэрэг бусад хүчин зүйлүүд ч нөлөөлсөн боловч нөлөөлөл нь бага хэмжээтэй байна. Харин хөгжиж буй зах зээлийн эдийн засагт Энэтхэг зэрэг зарим улс орнуудад энэ хугацаанд тэнцвэрт хүүгийн түвшин нэмэгдэж байгаатай холбоотой дүр зураг илүү холилдсон байдалтай байна.

Нөлөөлж буй хүчин зүйлс (хэвийн хүүгийн өөрчлөлтөд нөлөөлж буй хүчин зүйлс, %)

Хүн ам зүй болон нийт хүчин зүйлийн бүтээмжийн өсөлт нь хэвийн хүүгийн бууралтад нөлөөлж буй хүчин зүйлүүдийн нэг юм.



Sources: Platzer and Peruffo (2022); and IMF staff calculations.
Note: TFP = total factor productivity.

IMF

Бодит хүүгийн түвшний төлөв


Эдгээр хүчин зүйлсийн нөлөөлөл нь ирээдүйд тийм ч их өөрчлөгдөхгүй тул өндөр хөгжилтэй орнуудын хэвийн хүүгийн түвшин бага хэвээр байна. Хөгжиж буй зах зээлийн эдийн засагтай орнууд илүү дэвшилтэт технологи нэвтрүүлэхийн хэрээр хүчин зүйлийн бүтээмжийн нийт өсөлт нь өндөр хөгжилтэй орнуудын хурдтай ойртон нийлж, конвергенц хийх төлөвтэй байна. Мөн хөгжиж буй зах зээлийн эдийн засагтай орнуудын хүн амын хөгшрөлт нэмэгдэхийн хэрээр хэвийн хүүгийн түвшин урт хугацаанд хөгжингүй орнуудынх руу ойртож, буурах төлөвтэй байна.

Мэдээжийн хэрэг, энэ төсөөлөл нь далд хүчин зүйлсийн нөлөөллийн төсөөлөлтэй бараг ижил байна. Мөн цар тахлын дараах өнөөгийн нөхцөл байдалд, доорх таамаглалууд хамааралтай байж болно:

- Засгийн газрын дэмжлэгийг эргүүлэн татахад хүндрэл үүсч, засгийн газрын өр нэмэгдэнэ. Үүний үр дүнд ашигтай гэгддэг ховор, найдвартай, хөрвөх чадвар өндөр засгийн газрын бондыг эзэмшсэнийхээ төлөө хүү хэлбэрээр төлж буй хөрөнгө оруулагчдын урамшуулал буурч, хэвийн хүү өсөж болзошгүй.
- Төсвийн тэнцвэртэй бодлогоор цэвэр эдийн засагт шилжих нь (татвар, зохицуулалтын нөлөөллөөр) эрчим хүчний үнийг өсгөж капиталын ахиу бүтээмжийг бууруулдаг тул дунд хугацаанд дэлхийн хэвийн хүүгийн түвшинг бууруулах хандлагатай байна. Харин ногоон дэд бүтцэд чиглэсэн алдагдлыг төсвийн хөрөнгө оруулалтаар сахүүжүүлэх, татаас олгох зэрэг нь эсрэг үр дүнд хүргэх боломжтой.

- Даяаршлын сааруулалт эрчимжсэнээр олон улсын худалдаа, санхүүгийн хуваагдалд хүргэж, хэвийн хүүгийн түвшинг өндөр хөгжилтэй орнуудад нэмэгдүүлж, хөгжиж буй зах зээлийн эдийн засагтай орнуудад бууруулж болзошгүй юм.

Эдгээр хувилбаруудын хэвийн хүүгийн түвшинд үзүүлэх нөлөөлөл нь тус тусдаа харьцангуй хязгаарлагдмал хүрээнд байх ч нэгэн зэрэг, ялангуяа эхний болон гурав дахь хувилбаруудын хослол нь урт хугацаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх боломжтой.



Sources: LHS: Platzer and Peruffo (2022); and IMF staff estimates. RHS: G-cubed model; Global Integrated Monetary and Fiscal Model (GIMF); and IMF staff estimates.

Note: The fragmentation scenario encompasses both trade and financial fragmentation and is run with GIMF. The energy transition assumes balanced budget and is run with the G-cubed model. AEs = advanced economies; EMs = emerging market economies.

IMF

Төсөөлөл

Шинжилгээний үр дүнгээс харахад, сүүлийн үеийн бодит хүүгийн өсөлт түр зуурынх байх магадлалтай байна. Инфляцыг дахин хяналтандаа авснаар өндөр хөгжилтэй орнуудын төв банкууд мөнгөний бодлогоо зөөлрүүлж, бодит хүүг цар тахлын өмнөх түвшин рүү буцаах магадлалтай. Тэрхүү түвшинд хэр ойртох

нь засгийн газрын өр, алдагдал нэмэгдэх эсвэл санхүүгийн хуваагдал хэрэгжих эсэхээс хамаарна. Хүн ам зүй, бүтээмжийн ирээдүйн чиг хандлагын консерватив төсөөлөл нь хөгжиж буй томоохон зах зээлтэй эдийн засаг хөгжингүй орнуудын бодит хүүтэй аажмаар ойртож конвергенц үүсэхийг харуулж байна.

Эх сурвалж: <https://www.imf.org/en/Blogs/Articles/2023/04/10/interest-rates-likely-to-return-towards-pre-pandemic-levels-when-inflation-is-tamed>



УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САНХҮҮГИЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХАД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ



Н.Нинжин¹,



М.Анужин²

УДИРТГАЛ

Засгийн газар хоорондын уур амьсгалын өөрчлөлтийн зөвлөл (ЗГХУАӨЗ – *Intergovernmental Panel on Climate Change IPCC*)-ийн 2018 онд гаргасан тайлангаас үзэхэд, хүний буруутай үйл ажиллагаанаас үүдсэн уур амьсгалын өөрчлөлтийн явц цаашид эрчимжиж, дэлхийн гадаргын дундаж хэм 2030-2052 онд аж үйлдвэрлэлийн өмнөх үеийнхээс 1.5 °C-ээр нэмэгдэх хүлээлттэй байна. Үүний улмаас зөвхөн байгаль орчинд төдийгүй эдийн засгийн бүх салбарт томоохон эрсдэлүүд үүсэхээр байна. Төв банкны зүгээс уур амьсгалын өөрчлөлтөд анхаарах хоёр үндсэн шалтгаан байдаг. Нэгдүгээрт, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлүүд урт хугацаандаа инфляцын хэлбэлзлийг нэмэгдүүлж, төв банкны үндсэн зорилт болох **үнийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг**. Хэдийгээр уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл хэтийн ирээдүйд мэдрэгдэж эхлэх төлөвтэй ч төв банкууд одооноос эхлэн мөнгөний бодлогоор дамжуулан нүүрстөрөгчийн ялгарлыг цэвэр дүнгээр тэг байлгах зорилт (*net zero emissions*)-ыг дэмжиж ажиллах хэрэгцээ, шаардлага тулгарч байна. Хоёрдугаарт,

уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн банк, санхүүгийн байгууллагын чанаргүй активын хувь хэмжээ, хөрөнгө оруулалтаас хүлээх алдагдал нэмэгдэж, улмаар төлбөрийн чадвар буурч, **санхүүгийн салбарын тогтвортой байдал алдагдах эрсдэлтэй** юм. IPCC-2018 тайланд дэлхийн гадаргын хэм 1.5°C-ээр нэмэгдэхээр хүлээгдэж байгаа ба үүний нөлөөллийг бууруулах үүднээс хүний үйл ажиллагаанаас гаралтай нүүрстөрөгчийн хийн ялгарлыг 2030 он гэхэд 2010 оны түвшнээс 45 хувиар бууруулах, 2050 он гэхэд нүүрстөрөгчийн ялгарлыг цэвэр дүнгээр тэг (*net zero*) болгох зэрэг томоохон зорилтыг дэвшүүлсэн байдаг. Дээрх зорилтыг биелүүлж, ойрын ирээдүйд үүсэх дэлхийн дулаарлын хор хөнөөлийг багасгахын тулд дэлхийн бүх улс оронд нийгэм, эдийн засгийн бүхий л салбарыг хамарсан томоохон өөрчлөлтийг хэрэгжүүлэх замаар нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах шаардлага тулгарч байна. Нийгэм, эдийн засагт бүтцийн шинж чанартай өөрчлөлтийг хийхэд асар их хэмжээний санхүүжилтийн хэрэгцээ үүсэх нь гарцаагүй билээ. Санхүүгийн салбар нь аливаа улсын бодит эдийн засгийн гол тулгуур нь болдог тул дээр дурдсан хөрөнгө оруулалтын хэрэгцээг хангахад банк, санхүүгийн салбар голлох үүргийг гүйцэтгэх юм. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл нь эдийн засгийн бүх салбар, газарзүйн байршлыг хамарч байгаа бөгөөд үүнийг бууруулах арга хэмжээг одоо авч эхлэхгүй бол ирээдүйд үүсэх хор хөнөөлийг арилгах боломжгүй болох эрсдэл өндөр юм. Гэвч одоогийн байдлаар уур амьсгалын эрсдэлийг бүрэн үнэлж, активын үнэлгээнд шингээж тооцохгүй байгаа билээ [13].

¹ Монголбанкны Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын ахлах хянан шалгагч.

Цахим шуудан: ninjin@mongolbank.mn

² Монголбанкны Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын ахлах хянан шалгагч.

Цахим шуудан: anujin@mongolbank.mn

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ БА УДИРДЛАГА

Хүснэгт 1. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэх эрсдэлийн банкны салбарт үзүүлэх нөлөө

Эрсдэл	Зээлийн чанар	Зах зээл	Үйл ажиллагаа
Шилжилтийн эрсдэл	Актив болон барьцааа хөрөнгийн үнэлгээ буурна.	Эрчим хүчний болон түүхий эдийн үнэ өснө.	Хүрэн салбарт хөрөнгө оруулсан банкны нэр хүндийн эрсдэл нэмэгдэнэ.
	Зээлийн багцын үнэ цэнэ буурна.		
	Хүрэн салбарын хүлээгдэж буй дефолт болох магадлал нэмэгдэнэ.		
Биет эрсдэл	Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг салбар (жишээлбэл, ХАА, аялал жуулчлал)-ын дефолт болох магадлал нэмэгдэнэ.	Цаг агаарын онц ноцтой нөхцөл байдлаас үүдэн зээлдэгчид (зарим тохиолдолд улсын)-ийн зээлжих зэрэглэл буурна.	Төв салбар, мэдээл-лийн төвүүдийг шилжүүлэн нүүлгэх шаардлага үүсч болзошгүй.
	Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны таагүй нөлөөлөд өртсөн байршил дахь үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ буурна.		
Хариуцлагын эрсдэл	Үл хөдлөх хөрөнгө болон бусад хөрөнгөд хохирол болон алдагдал учирснаас шалтгаалан нийлүүлэлтийн сүлжээнд тасалдал үүснэ.	Даатгалын төлбөр нэмэгдэнэ.	

Эх сурвалж: [14]

Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан цаг агаарын онц ноцтой үзэгдлийн тоо, давтамж нэмэгдэхэд бизнесийн хэвийн үйл ажиллагааг хангахын тулд зарим байршил, бүс нутаг дахь банкны салбар, мэдээллийн төвүүдийг шилжүүлэн нүүлгэх хэрэгтэй болж болзошгүй нь салбарын хэмжээнд үүсэх томоохон үйл ажиллагааны эрсдэлд тооцогдоно. Үүнээс гадна, ногоон эдийн засагт шилжиж буй үед хүрэн салбарт хөрөнгө оруулалт хийх нь тухайн банкны нэр хүндэд сөргөөр нөлөөлж болзошгүй бөгөөд үүнийг нэр хүндийн эрсдэл (*reputational risk*) гэж тодорхойлно.

ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО

Сүүлийн үед уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан санхүүгийн салбарт учрах хор хөнөөл, таагүй нөлөөллийг бууруулах чиглэлд зохицуулагч байгууллагуудын зүгээс анхаарч, ихээхэн ач

холбогдол өгч байна. Тухайлбал, Хятадын ардын банк (ХАБ) болон Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ноос хамтран тус орны Банкны салбарын зохицуулалтын журам, Захиргааны хууль болон Арилжааны банкны тухай хууль дээр тус тус үндэслэн “Ногоон зээлийн зөвлөмж”-ийг батлан, банкны салбарт мөрдүүлж байгаа бөгөөд энэхүү зөвлөмжийн хүрээнд банк, санхүүгийн байгууллагууд ногоон зээлийг хянах, үнэлэх тогтолцоог бүрдүүлж ажиллах үүрэг хүлээсэн болно. Энэ мэтчилэн төв банк болоод бусад зохицуулагч байгууллага өөрийн Засгийн газраас баримталж хэрэгжүүлж буй ногоон хөгжлийн бодлогыг дэмжиж ажиллах болсон бөгөөд олон улсын түвшинд банк, санхүүгийн салбарын зохицуулагчдын зүгээс ногоон зээлийг дэмжихэд төрөл бүрийн тусгайлсан бодлогын хэрэгслийг ашиглаж эхлээд байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Ногоон санхүүжилтийн бодлогын хэрэгслүүд

Бодлогын төрөл	Хэрэгслийн төрөл	Ойлголт	Хэрэгжүүлэгч байгууллага
Макро зохистой бодлого	1. Стресс тест	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлийн санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөллийг үнэлэх;	Англи, Нидерландын төв банк хэрэгжүүлэхээр судалж байна.
	2. ӨХ-ийг ялгаатай тогтоох	Нүүрстөрөгчийн ялгарал өндөртэй салбарт олгосон зээлд илүү өндөр эрсдэлийн жин тогтоох;	Бразилийн төв банк
	3. Зээл/үнэлгээний харьцаа, зээл/орлогын харьцааны дээд хязгаар	Нүүрстөрөгчийн ялгарлын зорилтот түвшинд давсан салбар, эсвэл ААН-д олгох эх үүсвэрийн хэмжээг хязгаарлах;	
	4. Зээлийн хязгаарлалт	Банкаас нүүрстөрөгч их хэмжээгээр ялгаруулдаг ААН-д олгох зээлийн хэмжээг хязгаарлах;	
	5. Салбарын хөшүүргийн харьцаа	Нүүрстөрөгчийн ялгарал өндөртэй салбарт олгосон зээлийн хөшүүргийг хязгаарлах;	
	6. Хөрвөх чадварын хязгаарлалт	Уур амьсгалын өөрчлөлтийг хөрвөх чадвар/актив, пассивын эргэн төлөлтийн зөрүүтэй холбон хэрэгжүүлэхэд санхүүжилтийг тогтворжуулах хөрвөх чадварын харьцаа (LCR), тогтвортой санхүүжилтийн харьцаа (NSFR)-ны сэдлийн механизмыг бүрдүүлэх;	
Микро зохистой бодлого	1. Тайлагнал, толилуулга	Банкуудын уур амьсгалын өөрчлөлтөөс хүлээх санхүүгийн эрсдэлийн тайлан, толилуулга авах;	Уур амьсгалтай холбоотой толилуулгын ажлын хэсэг (TCFD)
	2. БОНЗ-ын эрсдэлийн удирдлага	Банкинд БОНЗ-ын эрсдэлийн удирдлагын аргачлал, стандартыг боловсруулж, мөрдөж ажиллах шаардлага тавих;	Бангладешийн төв банк, Хятадын ардын банк
	3. Заавал байлгах нөөц	Банкны ногоон салбараас татсан эх үүсвэрт харьцангуй бага ЗБН-ийн хувь тогтоох;	Ливаны төв банк
Зах зээлийн бодлого	1. Тогтвортой санхүүжилтийн зарчим	Банкуудад зөвлөмж өгөх;	Нигери улс
	2. Ногоон бондын зөвлөмж	Ногоон бонд гаргалтыг дэмжих зорилгоор ногоон бондын зөвлөмж боловсруулах;	Хятадын ардын банк, Хятадын ҮЦЗХ
Зээл, санхүүжилтийн бодлого	1. Зээлийн квот	Ногоон, байгаль орчинд ээлтэй салбарт банкнаас олгох зээлийн доод хувь хэмжээг тогтоох;	Энэтхэгийн төв банк
	2. Ногоон дахин санхүүжилтийн хэрэгсэл	Ногоон санхүүжилтийн санаачлагыг дэмжих тусгайлсан дахин санхүүжилтийн хэрэгсэл нэвтрүүлэх;	Бангладешийн төв банк
	3. Тэргүүн чиглэлийн салбарт хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл олгох	Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг салбарт хөнгөлөлттэй санхүүжилт олгох	Японы төв банк

Эх сурвалж: CCCU(2014); NGFS (2019); Энэтхэгийн төв банк (2015), [16][8][17]

МОНГОЛ УЛСАД ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ БУУРУУЛАХ, ШИНГЭЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцын Парисын хэлэлцээрийг 2016 оны есдүгээр сарын 1-нд соёрхон баталж, Засгийн газар хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарал (ХХЯ) нь дэлхийн нийт хүлэмжийн хийн ялгаралд маш бага хувь буюу 0.09 хувийг эзлэх боловч, нэг хүнд ногдох хүлэмжийн хийн ялгарал нь дэлхийн дунджаас 2.7 дахин их байна. Хүлэмжийн хийн ялгарлыг үндэсний хөгжлийн явцтай уялдуулан 2010-2030 оны байдлаар тооцож үзэхэд 2010 онд хүлэмжийн хийн ялгарал 25.8 сая тн CO₂-экв байсан бол 2030 онд 74.2 сая тн CO₂-экв болж 2.76 дахин өсөх төлөвтэй байна. Энэхүү өсөлтөд эрчим хүч, хөдөө аж ахуйн салбарын ялгарал зонхилох нөлөөг үзүүлсэн хэвээр байна. Хүлэмжийн хийн ялгарлын суурь хувилбар, бууралтыг тооцохдоо олон улсад баримталдаг арга зүйн дагуу эрчим хүчний болон эрчим хүчний бус салбар гэж авч үзсэн бол хүлэмжийн хийн шингээлтийн суурь хувилбар, шингээлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг тооцохдоо ойн салбарыг авч үзсэн байна.

МОНГОЛБАНКНААС НОГООН САНХҮҮЖИЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙД

Байгаль орчин, аялал жуучлалын яамнаас Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг банк, санхүүгийн салбарын хүрээнд дэмжин ажиллах шаардлага нөхцөл үүсч байна. Монголбанкны зүгээс санхүүгийн салбарт нөлөөлөх уур амьсгалын өөрчлөлтийг илрүүлэх, үнэлэх, удирдах зорилгоор Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлд “Тогтвортой, ногоон санхүүжилтийг хөгжүүлэх чиглэлд батлагдсан бодлого, хөтөлбөрийг олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх” зорилтыг тавин ажиллаж байна. Энэхүү асуудал нь Монгол Улсын мөнгөний бодлого, санхүүгийн тогтвортой байдлын ойрын болон дунд хугацааны тэргүүлэх чиглэлийн ажил болохоор байна. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо,

Сангийн яам, Хадгаламж даатгалын корпорацийн 2019 оны хамтарсан тушаалаар батлагдсан Ногоон таксономийн хүрээнд банкуудын олгож байгаа ногоон зээлийн тайланг Монголбанк нэгтгэн гаргаж байна. Банкны олгосон ногоон зээлийн багц нь нийт салбарын зээлийн багцын 1.43 хувийг эзэлж байна. Ногоон зээлийн хүрээнд банкны олгож байгаа зээлийн багцын ихэнх хувийг:

- i. **Эрчим хүчний хэмнэлт дэмжсэн зээл** нь нийт ногоон зээлийн багцын 29.4 хувийг эзэлж байгаа бөгөөд үүн дотор нарны цахилгаан эх үүсвэрийн зээл ихэнх хувьд нь олгогдсон байна. Нийт зээлийн 99.0 хувь нь хэвийн ангилалтай байна.
- ii. **Ногоон барилга дэмжсэн зээл** нь нийт ногоон зээлийн багцын 20.2 хувийг эзэлж байгаа бөгөөд ногоон барилга барих, ногоон барилгын материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, ногоон дэд бүтэц хөгжүүлэх зээлолгогдсон байна. Нийт зээлийн 96.4 хувь нь хэвийн ангилалтай зээл байна.
- iii. **Тогтвортой ус, хаягдлын хэрэглээ дэмжсэн зээл** нь ногоон зээлийн багцын 18.8 хувийг эзэлж байгаа бөгөөд тогтвортой ус ашиглалт, ус хэмнэх, усыг дахин ашиглах шинэ технологи, хаягдал ус, хог хаягдал цуглуулах, ангилах дахин боловсруулах байгууламж санхүүжүүлсэн зээл олгогдсон байна. Нийт зээлийн 87.2 хувь нь хэвийн ангилалтай.
- iv. **Тогтвортой хөдөө аж ахуй, газар ашиглалт, ой болон эко аялал жуучлал дэмжсэн зээл** нь ногоон зээлийн багцын 19.0 хувийг эзэлж байна. Тогтвортой хөдөө аж ахуй, органик хөдөө аж ахуйн болон мал аж ахуй, нэхмэл боловсруулалт ба үйлдвэрлэл чиглэлд дийлэнх зээл олгогдсон байна. Нийт зээлийн 85.8 хувь нь хэвийн зээл байна.

Банкны ногоон зээлийн санхүүжилт нь БОАЖЯ, БОУАС-аас тооцоолсон ХХЯ-ыг бууруулах суурь хувилбар болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд олгогдсон байгаа нь дээрх зээлийн

тайлангаас харагдаж байгаа ч зээлийн хэмжээ, хүртээмжийн хувьд хязгаарлагдмал байна.

ДҮГНЭЛТ, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

БОНЗ-ын эрсдэл багатай, ногоон бизнесүүдийн эрсдэлийн төвшин болон зээлжих зэрэглэлийг хүрэн бизнесээс ялгамжтай тогтоох боломжийг судлахдаа банкуудын нийт олгосон зээлийн багцын ХХЯ-ыг тооцоолж хэмжих нь нийт банкны салбарын байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөллийг судлах гол эхлэлийн цэг болно гэж үзэж байна. Түүнээс гарах үр дүнд ногоон болон хүрэн зээлийн ялгаа, хэмжээг гаргаж, нийт олгосон ногоон зээлийн чанарын үзүүлэлт, нийгэм эдийн засаг, байгаль орчинд нөлөөлж байгаа эерэг нөлөөллийг бодитой судалж, ногоон зээл олголтыг дэмжих хөшүүргийн хэрэгслүүдийг нэвтрүүлэн, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ногоон санхүүжилтийг дэмжих чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- i. Банкны салбараас олгож буй ногоон зээлийн багцад шинжилгээ хийж, greenwashing буюу шаардлага хангаагүй салбарыг ногоон

санхүүжилтэд хамааруулах явдал гарах эрсдэлийг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх эсвэл бууруулахад чиглэсэн арга хэмжээ авч ажиллах;

- ii. Банкны салбарт БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэх;
- iii. Банкны зээл болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчинд ялгарах хүлэмжийн хийг тоолж, тооцоолох аргачлалыг нэвтрүүлэн, ногоон болон хүрэн салбарыг ялган тодорхойлох;
- iv. Банкны салбараас олгож буй ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүний тоон мэдээг цуглуулах, өгөгдлийн санг бүрдүүлэх;
- v. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэх эрсдэлийг үнэлэх аргачлалыг судалж, манай орны банкны салбарт тохируулан нэвтрүүлэх;
- vi. Банкнаас уур амьсгалын өөрчлөлтөөс хүлээх санхүүгийн эрсдэлийн тайлан, толилуулга авдаг болох.

Санхүүгээ удирдах ухаалаг алхмууд

01



Өдөр
тутмын
зардлаа
хяна

02



Орж гарч буй
мөнгөө
харьцуул

03



Юунд мөнгө
зарцуулахаа
эрэмбэл

1. Өдөр тутмын зардлаа хяна

- Хүмүүс том хэмжээний зардал гаргасныхаа дараа л мөнгөний хомстолд ордог гэж боддог ч үнэн хэрэгтээ өдөр тутмын жижиг зардлуудад илүү их мөнгө үрэгдэж байдаг. Тиймээс таны мөнгө өдөр тутам хаашаа урсаад байгааг ойлгохоос санхүүгийн ухаалаг төлөвлөлт эхэлнэ.



2. Орж гарч буй мөнгөө харьцуул

- Өрх гэр бүлийн санхүүгээ хяналтандаа байлгах хамгийн шалгарсан арга бол төсөв гаргаж мөрдөх явдал. Энэ нь улсын эсвэл байгууллагын төсөв гаргаж батлах шиг нүсэр ажил биш. Ердөө л гэр бүлдээ орж ирсэн болон гарч байгаа мөнгөний урсгалыг ойлгож мэдэх аргачлал юм.



3. Юунд мөнгө зарцуулахаа эрэмбэл

- Гаргасан төсвөө эргэн харж дүгнэлт хийгээд мөнгөө юунд эхэлж зарцуулахаа эрэмбэл. Ингэснээр төсвийн тэнцэл буюу орлого, зарлагын зөрүүгээ зохистой болгож, хуримтлал хийх боломж, бололцоо нээгдэнэ.

